УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

Нийтийн ариун цэврийн байгууламжийн эрх зүйн зохицуулалт, тавигдах шаардлага: олон улсын зөвлөмж ба гадаадын зарим орны туршлага

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-23/211

2023.08.28

Хянасан: Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа

Судалгаа удирдсан: Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Ахлах зөвлөх Ц.Норовдондог (Ph.D.)

Судлаачид: Г.Алтан-Оч (Ph.D.), Д.Аюуш, О.Нарантуяа, Б.Батцэцэг, Ц.Ариунаа, Э.Дашзэгвэ, С.Золжаргал

УЛААНБААТАР
2023 ОН

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....2

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....3

ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....3

УДИРТГАЛ.....4

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....4

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ.....12

НЭГ. АРИУН ЦЭВЭР САХИХ ХҮНИЙ ЭРХ БА ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ.....12

1.1. Ус болон ариун цэврийн байгууламжтай байх хүний эрх.....12

1.2. Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо (ЗӨАОХ)-ны нийтийн ариун цэврийн өрөөний стандарт (ASEAN public toilet standart).....13

ХОЁР.НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....20

2.1. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС.....20

2.2. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС.....24

2.3. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС.....29

2.4. ЯПОН УЛС.....33

2.5. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС.....38

2.6. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС.....42

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....46

ХАВСРАЛТ.....49

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
ХЭДКГ	Хүний эрхийн дээд комиссарын газар (OHCHR)
ЗӨАОХ	Зүүн өмнөд азийн орнуудын холбоо (ASEAN)
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОУ	Олон улс
ҮБД	Үндэсний барилгын дүрэм
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман улс
АЦӨ	Ариун цэврийн өрөө
АБД	Ажлын байрны дүрэм
ЗББД	Зочид буудлын барилгын дүрэм
ОУСБ	Олон улсын стандартчиллын байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан орнуудын нийтийн ариун цэврийн өрөөний эрх зүйн орчин, тогтолцоо, стандартын талаар харьцуулсан мэдээлэл.....8
Хүснэгт 2. Худалдааны төвүүд (Их Британи).....28
Хүснэгт 3. Ажлын байр (Их Британи).....28
Хүснэгт 4. Нийтийн хоолны газарт байх АЦӨ-ний тоо.....43
Хүснэгт 5. Ажлын байранд байх АЦӨ-ний тоо.....44

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1."Happy Toilet"-ын байршлын зураг.....31
Зураг 2. "Happy Toilet" таних тэмдэг.....33
Зураг 3. Япон хэв маягийн (Вашики), барууны хэв маяг (Ёшики) бүхий ариун цэврийн өрөө 33
Зураг 4. Харааны бэрхшээлтэй хэрэглэгчдийн товчлуур (Япон).....36
Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулсан товчлуурын ажиллагаа.....36
Зураг 6. Японы Ариун цэврийн өрөөний аж үйлдвэрийн холбооноос Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны "Нийтийн ариун цэврийн өрөөнд угаах товчлуурыг байрлуулах олон улсын стандарт гаргасан"-д үндэслэн гаргасан.....37
Зураг 7. Бидэ (халуун устай бүлээн суултуур) бүхий барууны хэв маяг бүхий ариун цэврийн өрөө.....37

УДИРТГАЛ

“Нийтийн ариун цэврийн байгууламжийн эрх зүйн зохицуулалт, тавигдах шаардлага: олон улсын зөвлөмж ба зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго

Нийтийн ариун цэврийн өрөөний эрх зохицуулалт, тавигдах шаардлагын талаарх бусад орнуудын туршлага, энэ талаарх олон улсын зөвлөмж зэрэг мэдээллийг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ

Судалгаанд Австрали, Их Британи, Сингапур, Япон, Өмнөд Солонгос, Герман зэрэг орнуудын нийтийн ариун цэврийн байгууламжийн эрх зүйн зохицуулалт, тавигдах шаардлага зэрэг холбогдох мэдээллийг харьцуулан судлахын зэрэгцээ ариун цэвэр сахих хүний эрх ба нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах нийтлэг шаардлагын талаарх олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, судалгааны үр дүнгийн талаарх мэдээллийг оруулав.

Судалгааны тайлангийн бүтэц: Судалгаа нь 2 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт ариун цэвэр сахих хүний эрх ба нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах нийтлэг шаардлагын талаарх олон улсын зөвлөмж, гарын авлага, стандарт, Хоёрдугаар хэсэгт судалгаанд авагдсан орнуудын нийтийн ариун цэврийн байгууламжийн эрх зүйн зохицуулалт, тавигдах шаардлага, стандартын талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: ариун цэвэр сахих хүний эрх, нийт ариун цэврийн байгууламж, ариун цэврийн өрөө

Keyword: sanitary right, public toilet, toilet

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Олон улсын чиг хандлага

Ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн талаарх асуудлыг НҮБ-аас хүний эрүүл мэнд, нэр төр болон хөгжил цэцэглэлтийн үндсэн чухал асуудал гэж үзэн, “хүний эрх” гэж хүлээн зөвшөөрдөг. 2010 онд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар (OHCHR)-аас ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрхийн талаар **"Аюулгүй, цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх эрхийг хүний амьдрал, бүх эрхийг бүрэн дүүрэн эдлэхэд зайлшгүй шаардлагатай хүний эрх"** гэж хүлээн зөвшөөрсөн тогтоолыг баталсан байна. Тус тогтоолд хүний ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийг хангахдаа 1) олдоц, 2) хүртээмжтэй байдал, 3) боломжийн үнэ, 4) чанар, аюулгүй байдал, 5) хүлээн зөвшөөрөгдөх байдал зэрэг 5 шалгуурыг зайлшгүй хангах ёстой гэж оруулж өгчээ.

Нийтийн ариун цэврийн байгууламж, ариун цэврийн өрөөний тухайд дэлхийн улс орнууд нийтлэг байдлаар шаардлага, стандартуудыг мөрдөж байна. Эдгээрээс Зүүн өмнөд азийн орнуудын холбоо (ASEAN)-оос гаргасан **“Нийтийн ариун цэврийн өрөөний стандарт**”-ыг судалгаанд дэлгэрүүлэн авч үзлээ.

Энэхүү стандарт нь бүс нутгийн аялал жуулчлалын газруудын нийтийн бие засах газрын чанар, тав тух, аюулгүй байдал, хог хаягдлын зохистой менежментийг хангахад чиглэсэн бөгөөд 1) дизайн ба байгаль орчны менежмент 2) тав тухтай байдал ба

байгууламж, 3) цэвэр байдал, 4) аюулгүй байдал гэсэн үндсэн дөрвөн шалгуурт голлон анхаардаг байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлага:

Австрали

Австрали Улсад хувийн болоод нийтийн ариун цэврийн байгууламжтай холбоотой эрх зүйн асуудлыг 1) холбооны улсын түвшинд, 2) мужийн түвшинд гэж тус тусад нь авч үзэж байна. Австрали Улс нь бусад ардчилсан улсуудын адил хүний эрхийн болон ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийг хангасан конвенцуудад нэгдэн орсон байна. Ялгаатай нь тухайн гэрээний заалтууд нь Австралийн хууль тогтоомжид тусгайлан тусгагдаагүй л бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрддөггүй онцлогтой байна[1]. Австрали Улсад нийтийн ариун цэврийн өрөөний асуудал нь "Өмнөд Австралийн Нийтийн эрүүл мэндийн (Ерөнхий) дүрэм" (South Australian Public Health (General) Regulations), "Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм" (*Code of Practice for the Provision of Facilities for Sanitation and Personal Hygiene*) зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулагддаг байна. Эдгээр холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд Нийтийн эрүүл мэндийн зөвлөл, нийтийн эрүүл мэндийн ахлах байцаагч хяналт тавьдаг байна.

Харин байгууламжийг стандартыг "Үндэсний Барилгын Дүрэм" (National Construction Code)-д зааж өгч, холбогдох стандартуудыг хангуулдаг байна. Үндэсний барилгын дүрмийн нэгдүгээр боть, F4 Хэсэг[2] (Ариун цэврийн болон бусад байгууламжууд)-т, хавсралтын F2 хэсэгт[3] тус тус тогтоосон ангиллын байрнаас бие засах газар, бие засах газар, гар угаалтуур, ванн эсвэл шүршүүрийн талбай, угаалгын газар, гал тогооны угаалтуур гэх мэт зүйлсийн шаардлагууд байдаг.

ИБУИНХУ

ИБУИНХУ-д 1852 онд анх нийтийн ариун цэврийн байгууламж үүсч байжээ. Тус улсад нийтийн ариун цэврийн байгууламжийн тусгайлсан хууль байхгүй бөгөөд 1936 оны Нийтийн эрүүл мэндийн хуулийн 87 дугаарт *"Нийтийн ариун цэврийн байгууламж"* зүйл заалтаар иргэдийн хэрэгцээ шаардлагыг тухайн орон нутаг, мужийн засаг захиргаа бүрэн хариуцна гэж тусгасан. Орон нутаг, мужийн засаг захиргаа нь нийтийн ариун цэврийн байгууламжийг байгуулахдаа Барилгын тухай хууль, Усан хангамжийн тухай хууль болон BS6465 стандартыг баримтлан ажилладаг байна. Тус BS6465 стандарт нь ихэвчлэн барилга доторх ариун цэврийн байгууламжийн стандартыг тусгасан бөгөөд I хэсгийн 7.4 *"Нийтийн ариун цэврийн байгууламжийг ариун цэврийн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангахдаа орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлнэ*" гэж тодорхойлсон. Үүнээс үүдэн олон нийтийн эзэмшлийн гудамж талбайд байх нийтийн ариун цэврийн байгууламжийн тоо, байршил, байршлын мэдээлэл, хувиарлалт хүртээмж дутмаг байна, иймээс тусгайлсан хууль нэн шаардлагатай байна хэмээн үздэг байна. Иймд нийтийн ариун цэврийн байгууламжийг олон улсын жишиг стандартад нийцүүлэх, мөн хөгжлийн бодлого, нийгмийн

[1] Австрали Улс ба хүний эрхийн гэрээ конвенцууд: https://humanrights.gov.au/sites/default/files/content/education/hr_explained/download/FS7_Australia.pdf

[2] Австрали Улсын Үндэсний барилгын дүрэм(1-р ботийн F4 хэсэг): https://ncc.abcb.gov.au/editions/ncc-2022/adopted/volume-one/f-health-and-amenity/part-f4-sanitary-and-other-facilities

[3] Австрали Улсын Үндэсний барилгын дүрэм(1-р ботийн хавсралтын F2 хэсэг): https://ncc.abcb.gov.au/editions/2019-a1/ncc-2019-volume-one-amendment-1/section-f-health-and-amenity/part-f2-sanitary-and-dts

бодлого, хот, орон нутгийн бодлогод нийцүүлэх, нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий хот төлөвлөлт, хүн амын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзээд 2022 онд ИБУИНХУ-ын засгийн газраас нийтийн ариун цэврийн байгууламжийг тусгайлан зохицуулах хууль эрх зүйн орчин бүрдүүлэх шинэ хуулийн төсөл өргөн барьсан байна. Шинэ хуулийн төсөлд ариун цэврийн өрөөний стандартаас илүүтэйгээр нийтийн эзэмшлийн гудамж талбайд байгуулах ариун цэврийн байгууламжийн байршил, байршил хоорондын зай, байршлын мэдээлэл, тэмдэг тэмдэглэгээг чухалчлан тусгаж өгсөн. Мөн уламжлагдан ирсэн эрэгтэйчүүд 70%, эмэгтэйчүүд 30% гэсэн харьцаатай байсан ариун цэврийн байгууламжийн харьцааг эрх тэгш тоотой болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ариун цэврийн байгууламжийн тоног төхөөрөмж, стандартыг шинэчлэх, хүүхдийн живх солих өрөөг нэмэгдүүлэх зэрэг саналыг тусгажээ.

Сингапур

Сингапур Улсын нийтийн бие засах газрын үйл ажиллагааг Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрэм (Code of practice on environmental health), Нийтийн бие засах газрын дизайн, үйлчилгээг сайжруулах гарын авлага **(**A Guide to Better Public Toilet Design and Maintenance)-аар тус тус зохицуулж байна. Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрмийг нь Сингапурын Байгаль орчны үндэсний агентлаг (National Environment Agency) 2021 онд шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 2 дугаар бүлэгт нийтийн бие засах газрын төлөвлөлтийн шаардлагыг тусгасан байна. Харин Нийтийн бие засах газрын дизайн, үйлчилгээг сайжруулах гарын авлага **(**A Guide to Better Public Toilet Design and Maintenance)-ыг Сингапурын ариун цэврийн өрөөний холбоо (Restroom Association Singapore)-ооc 2022 онд баталсан. Уг гарын авлага 1) ариун цэврийн өрөөний дизайн, 2) засвар үйлчилгээ, 3) хэрэглэгчийн боловсрол гэсэн гурван бүлэгтэй.

Сингапур Улс нь судалж буй асуудалтай холбоотойгоор **"Happy Toilets хөтөлбөр”**-ийг 2003 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь хийц загвар, цэвэр байдал, хэрэглээ, үйлчилгээ, хэрэглэгчдийн сэтгэл ханамж гэсэн таван зарчимд төвлөрдөг санаачилга юм. Энэ хөтөлбөрийг Сингапурын ариун цэврийн өрөөний холбоо болон Байгаль орчны үндэсний агентлагаас дэмжин хэрэгжүүлдэг байна. 2023 оны байдлаар Сингапурт "Happy Toilets" таних тэмдэг бүхий 1300 гаруй нийтийн бие засах газар байгаа ба хөл хөдөлгөөн ихтэй зах, худалдааны төв, цэцэрлэгт хүрээлэнд ихэвчлэн байрлаж байна.

Япон

Япон Улсад нийтийн ариун цэврийн өрөөний асуудлыг Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай захирамжийг үндэслэн "Албаны эрүүл ахуйн стандарт журам", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ээр зохицуулж байсан бөгөөд 2021.12.01-ээс эхлэн бие засах газрын стандартууд өөрчлөгдөж **тусгайлсан “хувийн өрөөний төрлийн бие засах газар**"-ыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай журмын 628-2 т нэмж зааж өгсөн.

Бие засах өрөөний стандартын хувьд **Японы аж үйлдвэрийн стандарт** (Japanese Industrial Standarts-JIS)-ын холбогдох стандартуудыг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал, JIS A 5207:2022 Ариун цэврийн хэрэгсэл - Суултуур, угаалтуур, JIS A 4422:2011 халуун усаар угаадаг суудал (бидэ), JIS S 0026:2007 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан заавар, стандарт зэрэг стандартуудыг хэрэгжүүлдэг байна. Эдгээр стандарт, хууль дүрмийн хэрэгжилтийг Японы ариун цэврийн өрөөний нийгэмлэг (Japan Toilet Association-JTA), Японы ариун цэврийн өрөө судлалын хүрээлэн (Japan Toilet Labo-JTA) зэрэг байгууллагууд хариуцан ажилладаг байна.

БНСУ

БНСУ-д сүүлийн 40 орчим жилийн хугацаанд нийтийн ариун цэврийн байгууламжийн хангамж, менежмент, соёл хурдацтай хөгжсөн гэж үздэг. Ийнхүү хөгжихөд төрийн бодлого, үйл ажиллагаа, оролцоо болон төсөв санхүүгийн хөрөнгө оруулалт, төр-хувийн хэвшлийн түншлэл болон иргэдийн дэмжлэг хамгийн их нөлөө үзүүлжээ. Солонгос нь орчин үеийн нийтийн ариун цэврийн байгууламжийг хөгжүүлэх, сайжруулах үйл явцыг гурван үед хуваан авч үздэг байна. 1)Ариун цэврийн өрөөний хувьсгал (1986), 2) Үзэсгэлэнт ариун цэврийн өрөө-Beautiful Toilet (2000), 3)“Ногоон ариун цэврийн өрөө” (2011) зэрэг өөр өөрийн онцлогтой, зорилготой хөтөлбөр, кампанит ажлуудыг явуулжээ. Одоогийн байдлаар Нийтийн ариун цэврийн байгууламжтай холбоотой харилцааг 2004 онд батлагдсан Нийтийн ариун цэврийн өрөөний тухай хуулиар зохицуулж байна. Түүнчлэн Усан хангамж, усан байгууламж суурилуулах тухай хууль (Water supply and waterworks installation act, 1964), Ариутгах татуургын тухай хууль (Sewegare act, 1973), Барилгын тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоол (Enforcement decree of the building act, 1982) болон Ерөнхийлөгч, засаг захиргааны нэгжийн удирдлагаас баталсан журам, стандартуудыг дагаж мөрддөг байна.

ХБНГУ

ХБНГУ-д нийтийн хоолны газрын эрх зүйн зохицуулалт нь мужийн түвшний зохицуулалтанд хамаарах тул ариун цэврийн өрөө (АЦӨ)-ний стандартын талаарх нэгдсэн ерөнхий зохицуулалт байхгүй байна. Муж улс бүрт тавигдах шаардлага, нөхцөл нь ялгаатай, барилга, хот байгуулалт болон аж ахуын нэгжийн улсын бүртгэлийн алба нь нэгдмэл, энэ талаарх тусгайлсан хуулийн зохицуулалтгүй ч гэлээ нийтийн ариун цэврийн өрөөний стандартыг заавал шаарддаг байна.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 3 дахь заалтын 3 дахь хэсэгт заасан хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглох тухай, Тэгш эрхийг хангах ерөнхий хуулийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Берлин хотын Ялгаварлан гадуурхахын эсрэг-Тэгш эрхийг хангах муж улсын албанаас хүйсээр ялгаварласан ариун цэврийн өрөөнүүдийг цөөлөх арга хэмжээг 2018 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Хөдөлмөрийн эрх зүйд хамаарах акт болох “Ажлын байрны дүрэм”-д “ Ариун цэврийн өрөөг эрэгтэй, эмэгтэй гэж тусад нь байлгаж, тус тусдаа ашиглах боломж олгоно” гэж заасан. Ариун цэврийн өрөөг заавал хүйсээр ялгаж тус тусад нь байлгахыг албадан журамлаагүй ч гэлээ салангид ашиглах боломжийг хангах үүргийг үүгээр тогтоосон байна. Ариун цэврийн өрөөг ганцаарчилсан бүхээг байдлаар шийддэг байна.

(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан орнуудын нийтийн ариун цэврийн өрөөний эрх зүйн орчин, тогтолцоо, стандартын талаарх мэдээллийг харьцуулсан хураангуй хүснэгт

Улс	Хууль, эрх зүйн орчин	Тавигдах шаардлага/стандарт	Хариуцдаг байгууллага
Австрали	**“Өмнөд Австралийн Нийтийн эрүүл мэндийн (Ерөнхий) дүрэм”** (South Australian Public Health (General) Regulations) **“Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм”** (Code of Practice for the Provision of Facilities for Sanitation and Personal Hygiene)	**“Үндэсний Барилгын Дүрэм”** (National Construction Code) Нэгдүгээр хэсэг.F4 хэсэг. Ариун цэврийн болон бусад байгууламжуудын стандарт.	Өмнөд Австралийн эрүүл мэндийн комисс “Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм” батална. Дүрэм, журмын хэрэгжилтэд **Нийтийн эрүүл мэндийн зөвлөл, нийтийн эрүүл мэндийн ахлах байцаагч хяналт** тавьдаг .
Их Британи	Тус улсад нийтийн ариун цэврийн байгууламжийн тусгайлсан хууль байхгүй бөгөөд 1936 оны **Нийтийн эрүүл мэндийн хууль** (Public health Act 1936)-ийн 87 дугаар **“Нийтийн ариун цэврийн байгууламж”** зүйл заалтаар иргэдийн хэрэгцээ шаардлагыг тухайн орон нутаг, мужийн засаг захиргаа бүрэн хариуцна гэж хуульд тусгасан. **Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагааны хуулийн төсөл** (A Code of Practice for Public Toilets in Britian)	Барилгын тухай хууль, Усан хангамжийн тухай хуулийг үндэслэн **BS6465 стандарт (Ариун цэврийн байгууламжийн стандарт)**-ыг баримтлан ажилладаг байна. Тус BS6465 стандарт нь ихэвчлэн барилга доторх ариун цэврийн байгууламжийн барилгын стандартыг тусгаж өгсөн	**Ариун цэврийн байгууламжийн нийгэмлэг** (The British Toilet Association) Нийгэмлэг нь 160 гишүүнтэй 61 нь орон нутгийн засаг захиргаанаас бүрддэг. Тус байгууллага нь нийтийн ариун цэврийн байгууламжтай холбоотой дүрэм журмын хэрэгжилт, стандартын хангалт, хүртээмж, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэлт, мэдээллээр хангах, бусад орнуудын ариун цэврийн байгууламжийн төрөлжсөн холбоодтой харилцаа холбоо тогтоох зэрэг чиг үүрэгтэй байна.
Сингапур	**Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрэм** (Code of practice on	"Happy Toilets" стандарт 3 од буюу Clean Restrooms	**Сингапурын Байгаль орчны үндэсний агентлаг** (National Environment Agency)

	environmental health) **Нийтийн бие засах газрын дизайн, үйлчилгээг сайжруулах гарын авлага (**A Guide to Better Public Toilet Design and Maintenance)	4 од буюу Good Restrooms 5 од буюу Premium Restrooms 6 од буюу Magnificent Restrooms Нийтийн бие засах газар бүрийг дээр дурдсан шалгуурын дагуу Сингапурын ариун цэврийн өрөөний холбооны мэргэшсэн, бие даасан төлөөлөгчид үнэлж, ерөнхий стандартыг тодорхойлдог. Дараа нь "Happy Toilet" удирдамжтай харьцуулж, стандартад хүрсэн тохиолдолд 1-6 одны аль нэгийг олгодог байна.	Сингапурын нутаг дэвсгэр дээр барих аливаа барилга, байгууламжийн зураг төсөлд барилгын бүрдэл хэсэг болох хог хаягдлыг хадгалах, цуглуулах систем, нийтийн бие засах газар, агааржуулалт, гал тогооны яндангийн суваг, усны байгууламж, дахивар хадгалах, цуглуулах систем зэрэгт тавих стандартыг хэрэгжилтийг хангадаг байгууллага. **Сингапурын ариун цэврийн өрөөний холбоо** (Restroom Association Singapore) "Happy Toilets хөтөлбөр”-ийг хэрэгжүүлдэг байгууллага.
Япон	Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай захирамжийг үндэслэн **"Албаны эрүүл ахуйн стандарт журам"** болон **"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"** мөрдөгдөж байна. 2021 оны 12-р сарын 1-ээс бие засах газар суурилуулах стандартууд өөрчлөгдөж, шинэ "**бие даасан хувийн өрөөний төрлийн бие засах газар**" -ыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай журам[4]-ын	**Японы аж үйлдвэрийн стандарт** (Japanese Industrial Standarts-JIS) Дэд стандартууд: **JIS A 5207:2022** Ариун цэврийн хэрэгсэл - Суултуур, угаалтуур **JIS A 4422:2011** халуун усаар угаадаг суудал **JIS S 0026:2007** Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан заавар, стандарт	**Японы ариун цэврийн өрөөний нийгэмлэг** (Japan Toilet Association-JTA) Тус байгууллага 1985 онд байгууллагадсан бөгөөд ариун цэврийн өрөөний сайн орчныг бүрдүүлэх зэрэг нийтийн ариун цэврийн өрөөний хөгжилд анхаарал хандулдаг дэлхийн анхны байгуллагуудын нэг болсон. **Японы ариун цэврийн өрөө судлалын хүрээлэн** (Japan Toilet Labo-JTA) Энэ хүрээлэн нь ариун цэврийн байгууламжаар дамжуулан нийгмийг илүү сайнаар өөрчлөх үзэл баримтлалтай ажилладаг ашгийн бус байгууллага юм.

	628-2 т зааж өгсөн.		
Өмнөд Солонгос	**Нийтийн ариун цэврийн байгууламжийн хууль** (Public toilets act): Хуулийн зорилго нь нийтийн бие засах газрыг байгуулах, ашиглах, түүний эрүүл ахуйтай холбоотой харилцааг тодорхойлж, олон нийтэд эрүүл ахуйн ая тухтай, сайн сайхан байдлыг сурталчилахад хувь нэмэр оруулах юм. Энэхүү хууль нь 2004 онд батлагдсан, 22 зүйлтэй.	Нийтийн ариун цэврийн байгууламжийн хуульд зааснаар дараах стандартуудыг дагаж мөрдөнө. Үүнд: Ерөнхийлөгчийн баталсан стандарууд. - Хүүхдэд зориулсан тосгуур, суултуур суурилуулах стандарт - Нярай, бага насны хүүхдийн живх солих ширээний стандарт - Нийтийн ариун цэврийн байгууламжийн менежментийн стандарт Хот/муж/дүүргийн даргын баталсан стандарт: - Хөдөлгөөнт ариун цэврийн байгууламж суурилуулах, зохион байгуулах стандарт	**Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа хариуцсан зөвлөх хороо** Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа хариуцсан зөвлөх хороог хот/муж/дүүрэгт байгуулж, нийтийн ариун цэврийн байгууламжийг суурилуулах, зохион байгуулах, зохион байгуулалттай холбоотой дараах асуудлаар хот/муж/дүүргийн даргатай зөвлөлдөж асуудлыг шийдвэрлэдэг. **Солонгосын ариун цэврийн байгууламж нийгэмлэг** Ариун цэврийн өрөөтэй холбоотой бизнес эрхэлдэг хүмүүс, судалгаа, сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс ариун цэврийн байгууламжтай холбоотой судалгаа шинжилгээ, техник технологийн хөгжил, ариун цэврийн соёлыг зөв төлөвшүүлэх зорилгоор Солонгосын ариун цэврийн өрөөний нийгэмлэгийг байгуулж болдог.
Герман	ХБНГУ-д нийтийн хоолны газрын эрх зүй нь муж улсын түвшинд хамаарах тул ариун цэврийн өрөө (АЦӨ)-ний үүргийн талаар нэгдсэн ерөнхий зохицуулалт байхгүй учир муж улс бүрт тавигдах шаардлага, нөхцөл нь		

[4] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай журам https://elaws.e-gov.go.jp/document?lawid=347M50002000032

	ялгаатай байдаг байна. Гэвч барилга, хот байгуулалт болон аж ахун нэгжийн улсын бүртгэлийн алба нь нэгдмэл хуулийн зохицуулалтгүй ч гэлээ нийтийн АЦӨ-ний үүргийг заавал шаарддаг байна.		

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. АРИУН ЦЭВЭР САХИХ ХҮНИЙ ЭРХ БА ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ

1.1. Ус болон ариун цэврийн байгууламжтай байх хүний эрх

> “Аюулгүй ундны ус, хангалттай ариун цэврийн байгууламж нь ядуурлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах, мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.” *Бан Ги Мун, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан.*[5]

Цэвэр ундны ус, ариун цэврийн байгуулламжийн хүртээмжийг НҮБ-ээс хүн бүрийн эрүүл мэнд, нэр төр, хөгжил цэцэглэлтийн үндэс болох чухал “хүний эрх” гэж хүлээн зөвшөөрдөг. Хэдий тийм ч энэ байдал төдийлөн сайн хангагдахгүй байна.

Өнөөдөр дэлхий даяар 2 тэрбум орчим хүн ундны цэвэр усаар, 3.6 тэрбум буюу дэлхийн хүн амын 46 хувь нь шаардлагатай ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй байна гэж НҮБ-ын Дэлхийн усны хөгжлийн тайланд[6] дурджээ.

Усны эрх нь хүн бүр хувийн болон ахуйн хэрэгцээнд зориулан хангалттай, аюулгүй, хүлээн зөвшөөрөгдөхүйц, бие махбодийн хувьд хүртээмжтэй, хямд үнээр ус авах эрхийг олгодог.

Ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх нь хүн бүр амьдралынхаа бүхий л талбарт аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, нийгэм, соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн, хувийн нууцыг хангаж, нэр төрийг баталгаажуулсан ариун цэврийн байгууламжид бие махбодийн хэрэгцээгээ хангах үйлчилгээг боломжийн үнээр хүртээмжтэй авах эрхийг олгодог.

Энэ байдлыг сайжруулахын төлөө улс орнуудын засгийн газрууд ус, ариун цэврийн байгууламжийг барихдаа хүний эрхэд суурилсан арга барил (HRBA)[7]-ыг баримтлах ёстой талаар НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тайланд дурьджээ.

Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх (НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар – OHCHR)[8]

НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2010 оны 7-р сарын 28-нд **"Аюулгүй, цэвэр ундны ус, ариун цэврийн байгууламжтай байх эрхийг хүний амьдрал болон бүх эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд зайлшгүй шаардлагатай хүний эрх"** гэж хүлээн зөвшөөрсөн түүхэн тогтоолыг баталсан (A/RES/64). /292). 2015 оноос хойш Ерөнхий Ассамблей, Хүний эрхийн зөвлөл (OHCHR)-өөс ундны устай байх эрх, ариун цэврийн байгууламжтай байх эрхийг хоёуланг нь тусад нь хүлээн зөвшөөрч, ялгаатай хүлээж авсан.

Тус тогтоолд дараах шаардлагуудыг тусгасан. Үүнд:

Олдоц (availability): Хүн бүрийн усан хангамж нь ундны ус, хувцас угаах, хоол хүнс бэлтгэх, хувийн болон гэр ахуйн ариун цэврийг сахих зэрэг хувийн болон ахуйн хэрэглээг хангахад хангалттай бөгөөд тасралтгүй байх ёстой. Хүн бүрийн хэрэгцээг хангахын тулд өрх

---

[5] https://www.wvi.org/clean-water-sanitation-and-hygiene-wash/publication/disability-inclusive-wash-report 2014.11.26

[6] https://www.unesco.org/reports/wwdr/2023/en/download Дэлхийн усны хөгжлийн тайлан, 2023 он.

[7] https://unsdg.un.org/2030-agenda/universal-values/human-rights-based-approach The human rights-based approach (HRBA)

[8] https://www.ohchr.org/en/water-and-sanitation/about-water-and-sanitation Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах хүний эрх, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар

бүрийн дотор болон ойр орчмын ариун цэврийн байгууламж, эрүүл мэнд, боловсролын бүх байгууллага, ажлын байр болон бусад олон нийтийн газар хангалттай тооны ариун цэврийн байгууламжтай байх ёстой.

Хүртээмжтэй байдал (accessibility):: Ус, ариун цэврийн байгууламжууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүд, хүүхдүүд, ахмад настнуудыг оролцуулан тодорхой бүлгийн хэрэгцээг харгалзан хүн амын бүх давхаргад бие махбодийн хүртээмжтэй, аюулгүй хүрэх боломжтой байх ёстой.

Боломжийн үнэ (affordability):: Усны хангамж нь хүн бүрт хүртээмжтэй байх ёстой. Төлбөрөө төлж чадахгүй учраас ямар ч хувь хүн, нийгмийн бүлэг ундны цэвэр уснаас хүртэхгүй байж болохгүй.

Чанар, аюулгүй байдал (quality and safety):: Хувийн болон ахуйн хэрэглээний ус нь хүний эрүүл мэндэд заналхийлж буй бичил биетэн, химийн бодис, цацрагийн аюулаас ангид байх ёстой. Ариун цэврийн байгууламжууд нь эрүүл ахуйн хувьд аюулгүй байх ёстой бөгөөд шавьж, амьтан, хүний ялгадаснаас ангид байх ёстой.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал (acceptability):: Бүх ус, ариун цэврийн байгууламжууд нь боловсон бөгөөд хүйс, насны бүлэг, хувийн нууцлалын шаардлагуудад хангаж байх ёстой.

1.2. Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо (ЗӨАОХ)-ны нийтийн ариун цэврийн өрөөний стандарт (ASEAN public toilet standart)[9]

Энэхүү стандарт нь ЗӨАОХ (ASEAN[10])-ны зүүн өмнөд азийн бүс нутгийн аялал жуулчлалын газрууд дахь нийтийн бие засах газрын чанар, тав тух, аюулгүй байдал, хог хаягдлын зохистой менежментийг хангахад чиглэсэн бөгөөд 1) дизайн ба байгаль орчны менежмент 2) тав тухтай байдал ба байгууламж, 3) цэвэр байдал, 4) аюулгүй байдал гэсэн үндсэн дөрвөн шалгуурт анхаардаг байна.

Нийтийн бие засах газар

Нийтийн бие засах газар гэдэг нь нэг буюу хэд хэдэн угаах хэсэг, хог болон ус зайлуулах хаялагатай олон нийтийн бие засах газар, бие засах зориулалттай өрөө болон байгууламжийг хэлнэ. Нийтийн бие засах газрыг дараах байгууламжуудад байрлуулна. Үүнд:

- Худалдааны төвүүд болон түүний доторх дэлгүүрүүд;
- Супермаркет ба худалдааны захууд;
- Хоолны газар (ресторан, хоолны газар, баар, шөнийн клуб, диско, нийтийн далайн эргийн бие засах газар, паб);
- Гудамжинд, талбай дээр нийтийн бие засах газар дангаараа;
- Паркууд;
- Хөдөө болон хотын аялал жуулчлалын газрууд (жишээ нь: музей, оршуулгын газар гэх мэт);
- Вокзал, автобусны буудал, газар доорх галт тэрэгний буудал, галт тэрэг, онгоцны бие засах газар;
- Шатахуун түгээх станцууд;
- Үзэсгэлэнгийн танхим, концертын танхим, хурлын танхим, кино театр;
- Цэнгэлдэх хүрээлэнгүүд;
- Олон нийтийн төвүүд/клубууд;
- Нийтийн биеийн тамирын төвүүд, усан бассейнууд;

[9] https://www.asean.org/wp-content/uploads/2012/05/ASEAN-Public-Toilet-Standard.pdf Зүүн өмнөд Азийн орнуудын холбооны Нийтийн ариун цэврийн өрөөний стандарт

[10] ASEAN-Association of Southeast Asian Nations

- Хөдөө, хот суурин газрын өвийн дурсгалт газар, шашны дурсгалт газар, мөргөлийн газрууд.

Шалгуур, заавар

1) Дизайн ба байгаль орчны менежмент

Нийтийн бие засах газрын дизайны шалгуур нь дараах шаардлагуудыг хангасан байна.

- **Зам болон орц, гарц:** нийтийн бие засах газар байгааг харуулсан тод тэмдэг. Эмэгтэй, эрэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тэмдэглэгээг өрөөнүүдийн үүдний ойролцоо байрлуулсан байх ёстой. Тэмдэглэгээ нь олон нийтэд танигдахуйц байх ёстой (эмэгтэй/эрэгтэй/хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан бараан өнгөтэй, гэрэл цацруулагч дэвсгэр дээр ялгаатай тэмдэг). *Хавсралт 1-ийн зураг 1, 2, 3-ыг үзнэ үү.*
- **Нууцлал:** хаалгагүй, дотоод орчинг шууд харагдах боломжгүй, “зиг-заг” хэлбэрээр бүтээсэн орц-гарцыг хэлнэ. Гаднаас толинд суултуур, орц-гарцын хэсгийг харагдах байдлаас сэргийлж толийг хол байрлуулна. Суултуур хооронд хаалт нь хүнийг бүрэн халхлах байдлаар гэхдээ газарт бэхлээгүй, доогуур хөндий байх ёстой (энэ нь цэвэрлэхэд хялбар байдаг). *Хавсралт 1-ийн зураг 4, 5, 6-г үзнэ үү.*
- **Эмгэг төрүүлэгч дамжих замын хяналт**: шууд хүрэлцэх (гар/бие) гадаргууг багасгах (автомат цорго, автомат гар хатаагч, салфетка г.м.)
- **Зохистой харьцаа:** Эмэгтэй, эрэгтэй бие засах өрөөний харьцаа 5:3 байна. Жишээлбэл, эмэгтэй бие засах өрөө 5, эрэгтэй бие засах өрөө 3 байна.
- **Ариун цэврийн байгууламжийг хүрэлцээг хангалттай байлгах:** цэцэрлэгт хүрээлэн, цагаачлалын шалган нэвтрүүлэх цэг, худалдааны төв, автобус, галт тэрэг, онгоцны буудал, аялал жуулчлалын газар г.м. "олны хөл, хөдөлгөөнтэй цэг"-үүдэд ариун цэврийн байгууламж байх ёстой. Наад зах нь бие засах өрөөтэй байх ёстой. Орон нутгийн эрх баригчид Их Британийн одоогийн удирдамжийн нэгэн адил дор хаяж дараах зүйлийг хангахыг зөвлөж байна.
    - 550 эмэгтэй, эмэгтэй хүүхдэд 1-ээс багагүй ариун цэврийн өрөө;
    - 1100 эрэгтэйд 1-ээс багагүй ариун цэврийн өрөө (эсвэл 1 босоо суултуур);
    - 10,000 хүн амд нэгээс доошгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө;
    - 10,000 хүнд нэгээс доошгүй хүйс харгалзахгүй хүүхэд хуурайлах өрөө. Нийтийн бие засах газруудад ийм тусдаа өрөө байхгүй тохиолдолд энгийн (хөгжлийн бэрхшээлтэй) бие засах газарт зай байхгүйгээс хүүхэдтэй эхчүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие засах газар ашиглах хандлагатай байдаг. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан байгууламжийг олон зориулалтаар ашиглахыг зөвлөж байна (хөгжлийн бэрхшээлтэй - хүүхэд хооллох – хүүхдийн живх солих). Эдгээр тусгай газрууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан байгууламжийг олон төрлөөр ашиглаж болох тэмдэглэгээг байршуулах ёстой. Эдгээр байгууламжууд нь угаалтуур, саван, салфетка, эвхэгддэг живх солих сандал, хогийн сав, ариун цэврийн сав зэрэг тохижилттой байх ёстой. *Хавсралт 1-ийн зураг 7, 8, 9-ийг үзнэ үү.*
- **Тохижилт:** Тухтай, хувийн орон зайг хангасан, хялбар орц-гарцтай байх ёстой.
- **Үйлчлүүлэгчийн мэдээлэл:** Үйлчлүүлэгчдийн бие засах газар тамхи татахгүй байх, эрүүл ахуйн ач холбогдол, цэвэр ариун байдал, эмх цэгцтэй байх зэрэгт

чиглэсэн зурагт хуудсуудыг байрлуулж, үйлчлүүлэгчдийн зохистой, хариуцлагатай зан үйлийг хөгжүүлэхийн тулд дунд, урт хугацааны мэдлэг олгох хөтөлбөрийг орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх ёстой.

- **Хүртээмжтэй байдал:** Нийтийн ариун цэврийн байгууламж байгуулахдаа тухайн орон нутгийн засаг захиргаа, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, дүрэм, хууль тогтоомжийн шаардлагыг хангасан байх ёстой. Шаардлага байхгүй тохиолдолд бид дараах ерөнхий удирдамжийг санал болгож байна.
    - **Зам:** тэргэнцэртэй хүн хэн нэгний тусламжгүйгээр ашиглах боломжтой байх ёстой. Энэ нь гудамжны хамгийн ойрын зааг эсвэл машины зогсоолоос хүртээмжтэй бие засах газар хүртэл тасралтгүй үргэлжлэх бөгөөд хашлагатай байх ёстой. Хэрэв дээш өргөгдсөн бол хашлага бүхий налуу замтай байна;
    - **Хаалга**: хамгийн багадаа 80 см өргөнтэй хаалга байрлуулах хэрэгтэй. Энэ нь дотроосоо нээгдэх эсвэл гүйдэг хаалга байх ёстой;
    - **Өрөө**: өрөөний хувьд урт нь 1.5 м, өргөн нь 2.2 м багагүй байх ёстой;
    - **Суултуур:** Суултуурыг шалнаас дээш 43 см-ээс 48 см-ийн хооронд байрлуулж, хананаас хажуугийн зай нь 50 см-ээс ихгүй, арын хананаас ариун цэврийн өрөөний хамар хүртэлх нийт зай 75 см байх ёстой (Greed, 2007);
    - **Ариун цэврийн цаас:** ариун цэврийн цаасны савыг бие засах газрын өрөө буюу кабинд савны хажуугийн хананд байрлуулна. Диспенсерүүд нь савны хамгийн бага хэмжээнээс 10 см-ээс их зайд наалдаж болохгүй бөгөөд цаасыг суултуурын хамраас 30 см зайд, шалнаас 43 см-ээс 70 см-ийн зайд байрлуулах ёстой. Мэдрэгчээр идэвхжүүлсэн хогийн сав (гаргүй) болон доторлогоотой ариун цэврийн савыг суултуурын савны хажуу талд, ойр ойрхон байх ёстой;
    - **Гар угаалтуур**: гар угаалтуур нь бие засах газартай аль болох ойр байх ёстой бөгөөд ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрч болохуйц, янз бүрийн гадаргуу дээр бохир гар хүрэхээс сэргийлж, тэргэнцэрээс шилжиж буй хүнд саад болохгүй зайд байрлуулна. Гар угаалтуурыг суултуураас 110 см-ээс багагүй зайд байрлуулж, шалнаас ойролцоогоор 82 см өндөрт суурилуулсан байх ёстой бөгөөд тэргэнцэртэй хүмүүст ямар нэгэн холбох хэрэгсэлд саад учруулахгүйгээр угаах, арчлах үйл ажиллагааг хялбархан хийх боломжтой байх ёстой. Ус ирэх хоолой, ус зайлуулах хоолойг аль болох нуух хэрэгтэй; *Хавсралт 1-ийн зураг 10, 11, 12-ыг үзнэ үү.*
    - **Хүүхдэд хүртээмжтэй байдал**: гар угаалтуур, суултуур нь хүүхдийн өндөрт тохирсон байх ёстой. Хүүхдэд зориулсан суултуурын суудал байх нь тохиромжтой. *Хавсралт 1-ийн зураг 13, 14, 15-ыг үзнэ үү.*
    - **Хана:** Нийтийн бие засах газруудын хананы өнгө нь харааны бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд өнгөний тод ялгаатай байх ёстой.
- **Үерт өртөмтгий бүс эсхүл усан сантай ойрхон бүс:** ойр ойрхон үерт автдаг бүс нутагт (хот, хөдөө) эсвэл усны байгууламжтай ойрхон бол өндөр хуурай болон усны байгууламж барих хэрэгтэй. Цэвэр болон байгалийн усыг бохирдуулахгүйн тулд ялзмагийн “жорлон” хийхийг зөвлөж байна.
- **Соёлын өв болон байгалийн дархан цаазат газар**: Эдгээр газруудад байрлах нийтийн бие засах газар нь үндсэн шаардлагуудыг зайлшгүй хангасан байх ёстой. Нийтийн бие засах газрын байгаль орчны менежментийн тогтолцооны шалгуур нь ерөнхийдөө нийтийн бие засах газруудад зохих хог хаягдлын

менежмент, ус цэвэршүүлэх систем байгаа эсэхэд хамаарах бөгөөд эдгээрийг орон нутгийн засаг захиргаа болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрч, ашиглаж байна. Аудитын хяналтын хуудсанд Байгаль орчны удирдлагын тогтолцооны шалгуурууд нь дараах асуудлуудыг тусгайлан заана.

- Хог хаягдлын зөв менежмент, ус цэвэршүүлэх системийн талаар;
- Нөөц ба усны хэрэглээг хэмнэх талаар анхаарах зүйлсийн талаар; *Хавсралт 1-ийн зураг 16, 17, 18-ыг үзнэ үү.*
- Ундны усны хангамжийг зохих ёсоор хамгаалах талаар;
- Бохир усны зохистой менежментийн талаар;
- Ариун цэврийн өрөөний хог хаягдлын зохистой менежментийн талаар;
- Байгалийн гэрлийг ашиглах талаар;
- Цэвэрлэгээний бодисыг зөв ашиглах, харьцах талаар;
- Байгаль орчинд ээлтэй цэвэрлэгээний бүтээгдэхүүн хэрэглэх талаар;
- Тогтмол цэвэрлэгээ, үйлчилгээний талаар.

2) Тав тухтай байдал ба байгууламж

Нийтийн бие засах газрын тав тухтай байдал ба байгууламжийн шалгуур нь ерөнхийдөө холбох хэрэгсэл, эд хогшил, тохижилтын хангамжийг хэлнэ.

- **Холбох хэрэгсэл:**
  - Сантехникийн хэрэгсэл бүрийн нийлүүлэлтийн шугам, холбох хэрэгслийг эргэж тайлагдахаас сэргийлж суурилуулсан байх ёстой.
- **Бэхэлгээ:**
  - Сантехникийн холболтыг цэвэрлэх, засварлахад хялбар, ойр орчмын хананд тохирох байдлаар суурилуулсан байх ёстой.
  - Холболт нь нь хурц үзүүргүй, мөлгөр гадаргуутай байх ёстой бөгөөд шороо амархан хуримтлагддаг, цэвэрлэхэд хүрэхэд хэцүү байдаг далд гадаргуутай байж болохгүй.
  - Нийтийн бие засах газрын шугам, сангийн холболт нь ашиглалтын өндөр түвшинг харгалзан удаан эдэлгээтэй, өндөр чанартай байх ёстой бөгөөд орон нутгийн засаг захиргаа, эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжээс хүлээн зөвшөөрөгдсөн, тухайн салбарын холбогдох стандартад нийцсэн байх ёстой.
  - Нийтийн бие засах газрын холболт нь зэврэлтэнд тэсвэртэй материал ашигласан байх ёстой.
  - Нийтийн бие засах газрын гол хэрэгслүүд нь гар угаалтуур болон суултуур юм. Эдгээр нь хананаасаа 45 см, хоорондоо 90 см-ээс ойртох ёсгүй.
  - Ариун цэврийн өрөөнүүд нь 90 см-ээс багагүй өргөн, 152.4 см-ээс багагүй урттай байх ёстой.
- **Босоо суултуур:**
  - Босоо суултуур нь автомат ус зайлуулах төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой. Холболтуудыг сайн далдалсан байх ёстой. Энэ нь эвдрэл, гэмтэлээс сэргийлнэ. *Хавсралт 1-ийн зураг 19-ийг үзнэ үү.*
  - Хоёр ба түүнээс дээш тооны босоо суултуур суурилуулахдаа нэгийг нь хүүхдийн хэрэглээнд зориулж, энэ хэрэглээнд тохирсон өндөрт суурилуулах хэрэгтэй.
- **Гар угаалтуур:**
  - Угаалтуур нь гар угаах, үсээ арчлах үйл ажиллагаа явуулахаас гадна шалан дээр ус цацахаас сэргийлж зохих хэмжээтэй байх ёстой.

- Бүх угаалтруур нь ус хэмнэхийн тулд өөрөө хаагддаг цорготой байх ёстой. Мэдрэгчээр идэвхжүүлсэн цорго нь эрүүл ахуйг дээд зэргээр хангадаг гэж үзэж болно.
- Усны даралт, цорго, савны байрлал, урсгалын чиглэлийг ус цацахыг багасгахаар төлөвлөх ёстой.
- Хоёр ба түүнээс дээш угаалтуур байгаа бол ядаж нэгийг нь хүүхдэд хүрэх газар тогтоох хэрэгтэй.

- **Тав тухтай байдал:**
  Нийтийн бие засах газрын тохь тух нь дараахь зүйлийг агуулна.

<u>Дараах дагалдах хэрэгслийг зохих ёсоор хангана.</u>

- Хогийн сав (хөл гишгиж онгойдог) доторлогоотой.
- Ариун цэврийн сав (хөл гишгиж онгойдог) доторлогоотой.
- Гар хатаагч эсвэл салфетка
- Бие засах өрөө бүрт ариутгагч бодисууд
- Эмнэлгийн хурц үзүүртэй хаягдал хаях хэсэг
- Суултуур угаагч сойз
- Саван
- Суултуур
- Шүршигч *Хавсралт 1-ийн зураг 20,21-ийг үзнэ үү.*
- Усны хоолой (дор хаяж нэг өрөөнд)
- Толь
- Хувцасны өлгүүр (удаан эдэлгээтэй, хамгийн багадаа 7 кг ачааг даах чадалтай) өрөө бүрийн хаалганы ард байрлуулна.
- Цэвэрлэгээний материал
- Ариун цэврийн өрөө, шээс ариутгагч

<u>Нэмэлт хэрэглэгдэхүүнээр хангах, тухайлбал:</u>

- Наран шарлагын газрын бие засах газрын гадна талбайд шүршүүр байлгах
- Живх солих тавиур байлгах
- Ариун цэврийн өрөөний гадна талд цэврийн хэрэглэл байлгадаг автомат машин байлгах

3) Цэвэр байдал

Нийтийн бие засах газрын цэвэр байдлын шалгуур нь ерөнхийдөө нийтийн бие засах газрын бүх элементүүдийг (түүний дотор эд хогшил, өрөө, дагалдах хэрэгсэл, хана, шал гэх мэт) үргэлж цэвэр, хуурай байх ёстойг хэлнэ. Эдгээр шалгуурууд нь нийтийн ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, засвар үйлчилгээтэй холбоотой юм.

Аудитын хяналтын хуудасны цэвэр байдлын шалгуур нь дараах асуудлуудыг тусгайлан заадаг. Үүнд:

- **Агаарын чанар**: агаар сэлгэлт, чийгшлийн хяналт, өрөөний температур, агаар цэвэршүүлэгчийг тогтмол шинэчлэх
- **Агааржуулалтын систем:** үнэргүй байх, орчныг хуурай байлгах, ариун цэврийн өрөөний доторх температурыг хангах
- **Усны чанар**: Өнгөгүй, үнэргүй, бактергүй байх
- **Цэвэрлэгээний төрөл ба дараалал (өдөр тутмын/тогтмол/тусгай):** бие засах газрыг тогтмол ариутгах зорилгоор
    - Өдөр тутмын цэвэрлэгээ нь: цэгийн цэвэрлэгээ, нарийн цэвэрлэгээ гэж хуваагддаг.
    - Хуваарьт цэвэрлэгээ: тогтсон хуваарийн дагуу хуримтлагдсан толбо болон хүрэхэд хэцүү хэсгүүдийг (жишээ нь ус баригч, тааз, сэнс) цэвэрлэх
    - Тусгайлсан цэвэрлэгээ: үнэр, толбоны асуудлыг шийддэг, өдөр бүр/хуваарьт цэвэрлэгээгээр арилгах боломжгүй бохирдолыг цэвэрлэх (сард дунджаар нэг удаа хийдэг)
- **Хуваарьт цэвэрлэгээ:** цэвэрлэгээ хийх хугацаа, давтамжийг нарийвчлан зааж өгөх (өдөр тутмын/тогтмол/мэргэшсэн): Ариун цэврийн өрөөний дотор хананд харагдахуйцаар өлгөгдсөн хяналтын картыг өдөр тутмын цэвэрлэгээний засвар үйлчилгээг бүртгэх, хянах, хянах зорилгоор байрлуулж, үзлэгт оруулах
- **Сургалт:** цэвэрлэгч ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхийн тулд мэргэжлийн түвшинд бэлтгэгдэж, үндэсний итгэмжлэгдсэн сургалтын байгууллагуудаас гэрчилгээ авсан байх ёстой. Хянагч нар ариун цэврийн өрөөний цэвэр байдал, үйл ажиллагааны түвшинг шалгаж, хянах шаардлагатай ур чадвар эзэмшсэн байх ёстой.
- **Санал, хүсэлтийн хайрцаг:** нийтийн ариун цэврийн өрөөг хариуцсан байгууллага дагаж мөрдөх, сайжруулах талаар үйлчлүүлэгчдийнхээ саналыг цуглуулах зорилгоор өрөөний дотор санал, хүсэлтийн хайрцаг байрлуулсан байна.
- **Ерөнхий засвар үйлчилгээ:** гэмтэлтэй холбоосыг солих, жижиг засварын ажлыг гүйцэтгэх, ариун цэврийн өрөөнд гарсан осол/алдааг мэдээлэх систем бий болгох
- **Цагийн хуваарь:** тухайн газрын эрэлт хэрэгцээ, үйл ажиллагааны хэв маягт тохирсон нээх, хаагдах цагийн хуваарийг нийтийн бие засах газрууд ариун цэврийн өрөөний хажуугийн үүдэнд тодорхой байрлуулсан байхыг зөвлөж байна.
- **Байгалийн агааржуулалт:** байгалийн агааржуулалт нь цонх, хаалга, хөшиг эсвэл бусад сувгаар гадагш гардаг. Агаарын солилцоог 5 цаг тутамд хийнэ.
- **Механик агааржуулалт:** механик агааржуулалт (сэнс эсвэл агааржуулалтын сувгаар) нь агаарын солилцоог 15 цаг тутамд хийх хэрэгтэй.

4) Аюулгүй байдал

Нийтийн бие засах газрын аюулгүй байдлын шалгуур нь үйлчлүүлэгч, үйлчлэгч нарыг ариун цэврийн өрөөг аюулгүй ашиглах, нэвтрэх, гарах боломжийг хангахад чиглэгддэг. Мөн ариун цэврийн өрөөнд гэмт хэрэг үйлдэх, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг багтаана. Нийтийн бие засах газрын байршлыг зөв сонгох нь маш чухал юм.

Аудитын хяналтын хуудасны аюулгүй байдлын шалгуур нь дараах асуудлуудыг тусгайлан заадаг.

- **Усан хангамж, ус зайлуулах хоолойг далдлах**: төвлөрсөн усан хангамж, ус зайлуулах хоолойг эвдэж сүйтгэх үйлдлээс хамгаалахын тулд нуух хэрэгтэй.
- **Ариун цэврийн байгууламжийг түгжих**: Нээх, хаах цагтай нийтийн бие засах газрын хувьд (жишээ нь зарим аялал жуулчлалын газар, худалдааны төв гэх мэт) нийтийн ариун цэврийн өрөөний цонх, хаалгыг ажлын бус цагаар түгжихийг зөвлөж байна.
- **Хяналт**: Хамгаалалтын ажилтнууд нийтийн бие засах газрыг хүртэл анхааралдаа авахыг зөвлөж байна.
- **Тохиромжтой гэрэлтүүлэг**: Нийтийн бие засах газар ажиллаж байх үед гэрэлтүүлэгтэй байх ёстой.
    - **Дотор гэрэлтүүлэг:** байгалийн гэрэлтүүлэг байхгүй үед (ажлын цагаар) байх ёстой бөгөөд орц, гарц, угаалгын газар, ариун цэврийн өрөө, нийтийн хүртээл болохуйц гэрэлтүүлэгтэй байх ёстой.
    - **Гадна гэрэлтүүлэг:** байгалийн гэрэл байхгүй үед (ажлын цагаар) байнга асаалттай байх ба нийтийн бие засах газар орох шаардлагатай орц, гарц, явган хүний зам, зам, машины зогсоол, задгай талбайг гэрэлтүүлэхэд
- **Ерөнхий гэрэлтүүлэг:** ариун цэврийн өрөөг (ажлын цагаар) дулаан өнгөт гэрэлтүүлэгтэй болгож болно: дулаан өнгө нь ээлтэй орчныг бүрдүүлэхэд тусалдаг бөгөөд энэ нь хэрэглэгчийн илүү халамжтай зан үйлийг хөнгөвчлөхөд тусалдаг. Гэрэлтүүлгийг байгалийн болон хиймэл эх үүсвэрээс авах нь зүйтэй.
    - **Байгалийн гэрэл:** Байгалийн гэрлийг ашиглахдаа үндэсний стандартыг дагаж мөрдөх ёстой.
    - **Хиймэл гэрэл:** Орон нутгийн стандарт байхгүй тохиолдолд хиймэл гэрлийг ашиглах үед өрөөний талбайн гэрэлтүүлгийн дундаж хэмжээ 100-300 люкс байх ёстой бөгөөд ингэснээр зөв цэвэрлэх, зөв ашиглах, аюулгүй байдлыг хангах боломжтой.
- **Материал:** Нийтийн бие засах газар нь удаан эдэлгээтэй материалаар хангагдсан байх ёстой.
    - **Дотор:** бүх бэхэлгээ, холбох хэрэгсэл, хоолой, хавхлага, дагалдах хэрэгсэл нь цаг агаарын нөлөөлөл, ачаалал, эвдрэл, хүчтэй цэвэрлэгээ хийх гэх мэт нөлөөллийг тэсвэрлэх чадвартай байх ёстой. Шалыг ус нэвтэрдэггүй, хальтардаггүй материалаар хийсэн байх ёстой (жишээлбэл: чулуу, керамик хавтан, нано бүрээстэй нийлмэл боржин чулуу болон бусад бат бөх гадаргуу); хана нь удаан эдэлгээтэй гадаргуугийн материалаар бүрсэн байх ёстой (жишээлбэл, керамик хавтан, шилэн блок, байгалийн чулуу болон бусад бат бөх гадаргуу).
        - **Гадна:** Гадна гадаргууг аль болох удаан эдэлгээтэй, чанартай материалаар бүрсэн байх ёстой.
- **Цэвэрлэгээний аюулгүй байдал:** Нийтийн бие засах газрын үйлчлэгч нь цэвэрлэгээний химийн бодис болон тоног төхөөрөмжийг зөв хэрэглэх ёстой. Орон нутгийн зохицуулалтын шаардлагын дагуу үйлчлэгчдийг зохих даатгалд хамруулах ёстой.
- **CCTV хяналт:** CCTV хяналтын төхөөрөмжийг нийтийн бие засах газрын үүдний гадна замын хөдөлгөөн ихтэй газруудад (жишээлбэл: галт тэрэгний буудал, нисэх онгоцны буудал, метроны буудал гэх мэт) байрлуулах ёстой.

ХОЁР.НИЙТИЙН АРИУН ЦЭВРИЙН ӨРӨӨНИЙ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

Эрх зүйн орчин

Австралийн Холбооны улсын муж тус бүр өөрийн гэсэн хууль дүрэм, хууль тогтоох байгууллага, захирагчтай. Тиймээс хувийн болон нийтийн ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжтай холбоотой дүрэм журам, зааварчилгаа зэрэг холбогдох зохицуулалтыг холбооны, муж болон орон нутгийн эрх баригчид зэрэг засаг захиргааны янз бүрийн түвшний байгууллагууд тогтоож хэрэгжүүлдэг байна.

Холбооны түвшинд:

Нэгдэн орсон ОУ гэрээ:

Австрали Улс нь хүний эрхийн чиглэлийн дараах 7 гэрээнд албан ёсоор нэгдэн орсон байдаг[11]. Үүнд:

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ICCPR)
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ICESCR)
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (CRC)
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (CRPD)
- Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CERD)
- Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц (CAT).

Эдгээрээс дараах конвенцууд нь хүний цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхтэй шууд болон шууд бусаар холбогддог[12].

- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (ICESCR)
- Хүүхдийн эрхийн тухай конвенц (CRC)
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (CRPD)

Бусад ардчилсан улс орнуудаас ялгаатай нь Австрали улс олон улсын хүний эрхийн эдгээр томоохон гэрээ конвенцуудад албан ёсоор нэгдэн орсон хэдий ч тухайн гэрээний заалтууд нь Австралийн хууль тогтоомжид тусгайлан тусгагдаагүй л бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөгддөггүй онцлогтой байна[13].

Холбооны хууль, дүрэм, стандарт:

Холбооны түвшинд хувийн ариун цэврийн байгууламжтай холбоотой тусгайлсан хууль байхгүй боловч холбогдох барилгын норм, дүрэм, стандартын хүрээнд нэгдсэн зохицуулалт хийдэг.

---

[11] Австрали Улсын Хүний эрхийн хороо: https://humanrights.gov.au/our-work/education/human-rights-australia

[12] Хүний ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх: https://www.ohchr.org/en/water-and-sanitation/about-water-and-sanitation#:~:text=On%2028%20July%202010%2C%20the,RES%2F64%2F292).

[13] Австрали Улс ба хүний эрхийн гэрээ конвенцууд: https://humanrights.gov.au/sites/default/files/content/education/hr_explained/download/FS7_Australia.pdf

National Construction Code (NCC): Үндэсний Барилгын Дүрэм (ҮБД) нь Австрали даяар барилга, бусад байгууламжийн зураг төсөл, барилгын ажилд нэгдсэн заавар, техникийн заалтуудыг өгдөг. ҮБД-ийн Нэгдүгээр боть, F4 Хэсэг[14] (Ариун цэврийн болон бусад байгууламжууд)-т, хавсралтын F2 хэсэгт[15] тус тус тогтоосон ангиллын байрны эздээс бие засах газар, бие засах газар, гар угаалтуур, ванн эсвэл шүршүүрийн талбай, угаалгын газар, гал тогооны угаалтуур гэх мэт хувийн ариун цэврийг сахихад тохиромжтой хэрэгслээр хангахыг шаарддаг. Шалгуур, стандарт, нормыг тогтоосон байдаг.

Мужийн түвшинд (Өмнөд Австрали мужийн жишээгээр):

Өмнөд Австрали мужид хувийн болон нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага, шалгуур, стандарт, нормыг дараах хууль, дүрмээр зохицуулдаг. Үүнд:

- **Өмнөд Австралийн Нийтийн эрүүл мэндийн (Ерөнхий) дүрэм** (South Australian Public Health (General) Regulations):
- **“Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм”** (*Code of Practice for the Provision of Facilities for Sanitation and Personal Hygiene*):

Өмнөд Австралийн Нийтийн эрүүл мэндийн (Ерөнхий) дүрэм (South Australian Public Health (General) Regulations)[16]: Тус дүрмийн 11 дүгээр зүйлд: Өмнөд Австралийн эрүүл мэндийн комисс “Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм” батална. Энэхүү холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд Нийтийн эрүүл мэндийн зөвлөл, нийтийн эрүүл мэндийн ахлах байцаагч хяналт тавьна гэж заасан.

“Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм” (*Code of Practice for the Provision of Facilities for Sanitation and Personal Hygiene*)[17]: Тус дүрмийг Өмнөд Австралийн Ариун цэврийн комиссоос батлан гаргасан. Тус дүрэмд нэр томьёоны тайлбар болон ариун цэврийн байгууламжид тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг тодорхойлсон. Энэхүү дүрмийн хэрэгжилтэд нийтийн эрүүл мэндийн ахлах байцаагч (Chief Public Health Officer) болон нийгмийн эрүүл мэндийн зөвлөл хяналт тавьдаг.

Ерөнхий шаардлага:

1.Тоо: Тухайн барилгад байх ариун цэврийн байгууламжийн тоон ҮБД-ийн F2 хэсэгт заасан барилгын хэмжээ, ангиллаас хамаарна. Хэрвээ ҮБД-ийн ангилалд хамаарахгүй тохиолдолд шаардлагатай ариун цэврийн байгууламжийн тоо, төрлийг холбогдох эрх бүхий байгууллага тогтооно.

2.Холбогдох эрх бүхий байгууллагаас шаардсан нэмэлт тоноглол:

3.Сантехник, ус зайлуулах систем: Энэхүү дүрмийн шаардлагыг хэрэгжүүлэх үүднээс бүх ариун цэврийн байгууламжийн сантехник, ус зайлуулах байгууламж, түүний дотор бэхэлгээ, холболтыг суурилуулахдаа дараах шаардлагыг хангасан байх ёстой.

---

[14] Австрали Улсын Үндэсний барилгын дүрэм(1-р ботийн F4 хэсэг): https://ncc.abcb.gov.au/editions/ncc-2022/adopted/volume-one/f-health-and-amenity/part-f4-sanitary-and-other-facilities

[15] Австрали Улсын Үндэсний барилгын дүрэм(1-р ботийн хавсралтын F2 хэсэг): https://ncc.abcb.gov.au/editions/2019-a1/ncc-2019-volume-one-amendment-1/section-f-health-and-amenity/part-f2-sanitary-and-dts

[16] Өмнөд Австрали Мужийн Нийтийн эрүүл мэндийн ерөнхий дүрэм: https://www.legislation.sa.gov.au/__legislation/lz/c/a/south%20australian%20public%20health%20act%202011/current/2011.21.auth.pdf

[17] Өмнөд Австрали Мужийн “Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм”: https://www.sahealth.sa.gov.au/wps/wcm/connect/df72a18047b216389e61de7c69742d6b/17178.2+Sharps+Disposal+Code+A4+Booklet-ONLINE.PDF?MOD=AJPERES&CACHEID=ROOTWORKSPACE-df72a18047b216389e61de7c69742d6b-nKLanMg

- Өмнөд Австралийн Нийгмийн Эрүүл Мэндийн (Бохир ус) дүрэм, Газар дээрх бохир усны системийн дүрэм
- AS/NZS 3500: 2013 Сантехник, ус зайлуулах хоолой (0-5-р хэсэг)

- Австралийн Үндэсний Барилгын Дүрэм (NCC) 3-р боть Сантехникийн дүрэм (Хавсралт А-д жагсаасан SA-ийн өөрчлөлтүүд ба/эсвэл нэмэлт заалтуудыг багтаасан)

4.Шал, ханын тусгаарлалт, тааз: Шал, хана, тааз, хуваалт нь хатуу, бат бөх, ус үл нэвтрэх материалаар хийгдсэн байх ёстой бөгөөд тэдгээрийг цэвэрлэхэд хялбар, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд байлгахыг баталгаажуулна.

5.Бэхэлгээ ба холбох хэрэгсэл: Ариун цэврийн болон хувийн ариун цэврийг сахихад ашигладаг бэхэлгээ, холбох хэрэгсэл нь удаан эдэлгээтэй, эвдрэлд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар, байнга хэрэглэхэд тэсвэртэй байх ёстой.

6.Гэрэлтүүлэг: Аюулгүй байдал, үр дүнтэй цэвэрлэгээг хангахын тулд бүх байгууламжийг хангалттай гэрэлтүүлгээр хангасан байх ёстой. Боломжтой бол холбогдох бүх байгууламжид цонх, дээврийн цонх эсвэл үүнтэй төстэй байгалийн гэрэлтүүлгийг суурилуулах хэрэгтэй. Өдрийн цагаар ажиллах боломжтой эсвэл хангалттай байгалийн гэрэлтүүлэггүй байгууламжийг зохих хиймэл гэрэлтүүлэгтэй болгоно. Хиймэл гэрэлтүүлэг шаардлагатай тохиолдолд NCC болон AS/NZS 1680: 2009 0-р хэсэг, дотоод гэрэлтүүлгийн аюулгүй хөдөлгөөнд заасны дагуу суурилуулсан байх ёстой.

7.Агааржуулалт: Үнэрийг арилгах, конденсац үүсэх, хөгц үүсэхээс урьдчилан сэргийлэхийн тулд цонх, агааржуулалт, дээврийн суваг, механик яндангийн систем эсвэл түүнтэй адилтгах агааржуулалтыг суурилуулах шаардлагатай. ҮБД-ийн F4.6-д нийцсэн байгалийн агааржуулалт эсхүл AS 1668.2 ба AS/NZS 3666.1 стандартад нийцсэн механик агааржуулалт болон агааржуулалтын систем суурилуулахыг шаарддаг. Холбогдох эрх бүхий байгууллага (өөрийн үзэмжээр) тодорхой нөхцөлд механик агааржуулалтын байгууламж шаардлагатай гэж үзэж болно. Байшингаас зайлуулсан яндан нь ойролцоох байрны оршин суугчид үнэр ялгаруулж эвгүй байдалд оруулахгүйн тулд байшингийн дээврээс дээш гадагшлуулах ёстой.

8.Бохир, бохир ус, саарал усны систем: Бохир усны системийг Өмнөд Австралийн хууль тогтоомж, техникийн дүрмээр зохицуулдаг. Байшин нь SA Усны дэд бүтцэд холбогдоогүй тохиолдолд бохир усыг олон нийтийн бохир усны менежментийн схемд (CWMS) цутгах эсвэл тухайн газар дээрх зохих бохир усны системээр зайлуулах шаардлагатай. CWMS болон газар дээр нь зайлуулах нь 2013 оны Өмнөд Австралийн Нийгмийн Эрүүл Мэндийн (Бохир ус) журам болон Газар дээрх бохир усны системийн дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх бөгөөд холбогдох байгууллагаас өргөдөл, үнэлгээ, зөвшөөрөл шаарддаг. Саарал усыг цэвэршүүлэх, дахин ашиглах, зайлуулах нь 2013 оны Өмнөд Австралийн Нийгмийн Эрүүл Мэндийн (Бохир ус) дүрэм болон Байшин дахь бохир усны системийн дүрмийн шаардлагад нийцсэн байх ёстой. Хэрэв тухайн байр нь бохир ус зайлуулах холболтын цэгээр хангагдсан бол уг холболтыг хангадаг усны аж ахуйн нэгжээс зөвшөөрөл авах шаардлагатай.

9.”Жорлон”-ийн өөр хувилбарууд – усны хэрэглээг багасгасан: Усны хүрэлцээ муутай газруудад (жишээлбэл, хөдөө орон нутаг эсвэл муж улсын алслагдсан бүс нутаг) бордоо, химийн бодис эсвэл бусад ижил төстэй “жорлон” ашиглахыг авч үзэж болно.

Орон сууцны бус нийтийн зориулалттай байранд тавигдах тусгай шаардлага

Худалдааны төв, автобусны бааз, зоогийн газар, худалдааны барилга гэх мэт нийтийн бие засах газар, цэцэрлэгт хүрээлэн, дархан цаазат газарт бие даасан ариун

цэврийн байгууламжууд нь орон сууцны байранд тавигдах шаардлагад нэмэлт шаардлага тавьдаг.

1.Гар хатаах төхөөрөмж, савангаар хангах: Гарын ариун цэврийг сахих нь ханиад, томуу, ходоод гэдэсний үрэвсэл зэрэг өвчин үүсгэдэг эмгэг төрүүлэгч бичил биетний тархалтаас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй аргуудын нэг гэж тооцогддог. Боломжтой бол нийтийн бие засах газруудад урсгал ус, шингэн саван, гараа хатаагч хэрэгслийг (нэг удаагийн цаасан алчуур эсвэл агаар хатаагч гэх мэт) тасралтгүй нийлүүлэх ёстой. Холбогдох эрх бүхий байгууллагаас шаардлагатай гэж үзвэл гараа хатаах саван, хэрэгслээр хангах шаардлагыг 92-р зүйлийн мэдэгдлээр хэрэгжүүлж болно.

2.Гадна шүршүүр: Далайн эрэг, дотоод усан зам зэрэг амралт зугаалгын газруудад угаах зориулалттай гаднах шүршүүр суурилуулсан бол бохир усыг энэ дүрмийн 3.8-д заасан шаардлагын дагуу зайлуулах шаардлагагүй.

3.Нярайн асаргааны төхөөрөмжүүд: Аж ахуйн нэгж эсвэл холбогдох байгууллага нь нялхсын асрамжийн газрыг тусад нь олгохоор шийдсэн бол уг байгууламж нь аль аль хүйсийн хүмүүст тохиромжтой байх ёстой. Тус байгууламж нь хувцасны шүүгээ, гар угаах хэрэгсэл, хувцас солих сандал, нэг удаагийн живх болон бусад бохирдсон материалыг хадгалах, зайлуулах савтай байх ёстой. Холбох хэрэгсэл, бэхэлгээ нь бага насны хүүхдэд тохиромжтой хэмжээтэй байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан унисекс байгууламжийг нялхсын асрамжийн газартай хослуулсан тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан талбайг вандан сандал, хогийн сав, хадгалах шүүгээгээр хааж болохгүй. Хүүхдийн хувцас солих хэрэгслийг AS 1428.1 ба 1428.2-ын дагуу боломжтой бөгөөд боломжийн бол тахир дутуугийн байранд орох боломжтой болгоно.

4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төхөөрөмжүүд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ашиглахад шаардагдах байгууламжийн тоо нь ҮБД-ийн шаардлагад нийцсэн байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан нэвтрэх эрх нь Австралийн стандарт 1428.1, Хандалт, хөдөлгөөнд зориулсан загварт нийцсэн байх ёстой.

5.Засвар, үйлчилгээ, цэвэрлэгээ: Ариун цэврийн болон хувийн ариун цэврийн байгууламжийг цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд байлгах ёстой. Байгууламжийг тогтмол шалгаж, шаардлагатай бол засвар үйлчилгээ хийж байх ёстой бөгөөд байнгын болон удаан хугацаагаар ашиглах боломжтой, мөн хүнд нөхцөлд ашиглах боломжтой байгууламжууд нэмэлт хяналт, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ шаарддаг. Гэмтэл, гэмтэлтэй тоног төхөөрөмж эсхүл цэвэрлэгээ, засвар үйлчилгээ хийх хэрэгцээг мэдэгдэх холбоо барих хаягийг нийтийн бие засах газруудад тодорхой харуулсан байх ёстой.

6.Хатуу хог хаягдал зайлуулах: Ашигласан живх, ариун цэврийн хэрэглэл, шээс ялгаруулах дэвсгэр, цаасан алчуур болон бусад хог хаягдлыг зайлуулах зориулалтын савтай байх ёстой. Хог хаягдлыг хадгалахад ашигладаг бүх савыг сайтар засварлаж, цэвэр, эрүүл ахуйн нөхцөлд байлгах ёстой. 2013 оны Өмнөд Австралийн Нийгмийн эрүүл мэндийн (ерөнхий) дүрмийн 7 дугаар журмын дагуу; Тухайн байрны өмчлөгч буюу оршин суугч нь тухайн байранд байгаа хог хаягдлыг хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулах буюу эрсдэлтэй байлгах үүднээс зохих арга хэмжээ авах ёстой.

—(а) байранд байхдаа саванд хадгалсан бол:

(i) хог хаягдлыг зохих ёсоор хадгалах чадвартай, хог хаягдлаас гарах аливаа эвгүй үнэр, шингэнийг агуулсан байх;

(ii) хортон шавж, хортон шавж болон бусад амьтдад хүрэх боломжгүй;

(iii) ус үл нэвтрэх;

(iv) цэвэр, эрүүл нөхцөлд;

(б) хог хаягдлын шинж чанарыг харгалзан аль болох олон удаа хог цуглуулах үйлчилгээгээр цуглуулах боломжтой болгосон.

Дүрэм, энэхүү дүрмийн шаардлагыг дагаж мөрдөхийн тулд байгууламжид хог хаягдлын хуримтлалыг тогтмол хянаж байх нь чухал юм. Бүх хог хаягдлыг 1993 оны Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу устгах ёстой.

Хурц үзүүртэй эд зүйл устгах шаардлага

Хүмүүс хурц үзүүрийг (зүү, тариур, эмнэлгийн ланцет гэх мэт) эрүүл мэндийн тодорхой нөхцөл байдлыг хянах эсвэл тарилгын эм, хууль бус эмийг хэрэглэхэд ашигладаг. Нийтийн бие засах газруудад хурц үзүүртэй хэрэгсэл хаях зориулалт бүхий багаж хэрэгслээр хангаснаар хурц үзүүртэй багажийг аюулгүй устгахад дэмжлэг үзүүлж, хууль бусаар болон зохисгүй устгасан хурц үзүүртэй багажтай санамсаргүй хүрэлцэх замаар гэмтэх эрсдэлийг бууруулдаг.

1.Хурц үзүүртэй эд зүйл агуулах сав: Нийтийн бие засах газар дахь хурц үзүүрийг хаях байгууламжууд нь ихэвчлэн металл хийцээр хийсэн цоожтой гадна хананд байрлуулсан, дахин ашиглах боломжгүй, хатуу, цоордоггүй савнаас бүрддэг. Хурц үзүүртэй савыг дүүргэх шугамаас хэтрүүлэхгүйгээр 14 см урттай зүйлийг багтаах чадвартай байх ёстой бөгөөд Австралийн холбогдох стандартыг дараах байдлаар хангасан байх ёстой.

- AS 4031 – 1992: Эрүүл мэндийн байгууллагад ашигладаг хурц үзүүртэй эмнэлгийн эд зүйлсийг цуглуулах зориулалттай дахин ашиглах боломжгүй сав
- AS/NZS 4261 - 1994: Хүн, амьтны анагаах ухаанд ашигладаг хурц үзүүртэй зүйлсийг цуглуулах зориулалттай дахин ашиглах боломжтой сав.

Эдгээр стандартын дагуу савыг шар өнгөтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн биологийн аюулын тэмдэгтэй, савыг дүүргэх шугамаас дээш дүүргэж болохгүй гэсэн тэмдэглэгээтэй байхыг шаарддаг.

2.Суурилуулалтын өндөр: Нийтийн бие засах газар дахь хурц үзүүртэй хогийн савыг газраас савны онгойлгох хүртэл 1300мм-ээс багагүй өндөрт байрлуулна. Энэ өндөр нь хүүхдийн хурц үзүүртэй савны агууламжтай санамсаргүй хүрэлцэх магадлалыг бууруулж, тэргэнцэртэй хүмүүс (ямар нэгэн саад бэрхшээлгүй бол хажуу тийш) болон түргэн тусламжийн хүмүүст уг савыг хажуугийн "хүргэх" хязгаарт багтаахыг баталгаажуулна. хөгжлийн бэрхшээлтэй. Хандалтын болон хөдөлгөөнт байдлын дизайны талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Австралийн стандарт AS1428, 1992 – Хандалт ба хөдөлгөөнд зориулсан загвар – 2-р хэсэг: Сайжруулсан болон нэмэлт шаардлага – Барилга байгууламжаас үзнэ үү.

3.Мониторинг ба удирдлага: Хурц үзүүртэй савны хэмжээ нь хүлээгдэж буй хог хаягдлын хэмжээнд тохирсон байх ба шаардлагатай бол тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээ хийх ёстой. Эдгээр савны агуулгыг зохицуулалтын шаардлагын дагуу устгах ёстой. Зохисгүй хаясан, хаясан хурц үзүүртэй багажийг эрт илрүүлж, устгахын тулд хурц үзүүртэй бодис устгах байгууламж байрладаг газруудыг тогтмол шалгаж байх ёстой. Дүүрсэн, дүүрсэн эсвэл гэмтсэн хурц үзүүртэй бодисыг устгах байгууламжийн талаар мэдээлэх боломжийг олгохын тулд тодорхой тодорхойлогдох холбоо барих цэгийг өгөх ёстой. энэ байж магадгүй. 2012 оны Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн дагуу хурц үзүүртэй бодис устгах байгууламжид хяналт тавих, засвар үйлчилгээ хийх үүрэг, журмыг тодорхой тодорхойлж, баримтжуулж, ажилчдыг үүргээ биелүүлэхийн тулд зохих ёсоор сургасан байх ёстой.

4.Эх сурвалж: зүү, зүүгээр гэмтэх эрсдэлийг бууруулах зорилгоор мужийн Эрүүл мэндийн газар (SA Health)-аас олон нийтэд анхааруулах тэмдэг гаргажээ.

2.2. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

ИБУИНХУ-д 1852 онд анх нийтийн ариун цэврийн байгууламж бий болжээ. 1936 оны Нийтийн эрүүл мэндийн тухай хуулийн "*Нийтийн ариун цэврийн байгууламж*" гэсэн зүйлд "*Ариун цэврийн байгууламжийн шаардлагыг орон нутгийн засаг захиргаа хариуцна"* гэж хуульчилсан бөгөөд энэ заалт одоо мөрдөгдөж байна. Орон нутгийн засаг захиргаанаас BS6465 гэсэн стандартын дагуу нийтийн ариун цэврийн байгууламжийг барьж байгуулдаг. Уг стандартын I хэсгийн 7.4-т *"Нийтийн ариун цэврийн байгууламжийн тоног төхөөрөмж, байршил, засвар үйлчилгээг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлнэ*" гэж заасан нь барилгын тоонд хамаарч ариун цэврийн байгууламжийн тоог тогтоох, ариун цэврийн өрөөний тоног төхөөрөмж, холболт сантехникийн асуудал зэргийн стандартыг нарийвчлан тогтоосон байна. Тиймээс уг стандартад нийтийн эзэмшлийн гудамж талбайд байгуулах ариун цэврийн байгууламжийн тоо, байршил, таних тэмдэг тэмдэглэгээ, нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах эрүүл ахуйн шаардлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоног төхөөрөмжийн стандарт учир дутагдалтай байгаа нь нийтийн ариун цэврийн байгууламжийн стандартыг шинэчлэх, тусгайлсан хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэн шинэ хуулийн төслийг 2022 онд засгийн газартаа танилцуулаад байна.

Хууль эрх зүйн орчин

Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль1936 (Public health Act 1936)[18]

87 дугаар зүйл.Нийтийн ариун цэврийн байгууламж:

1. Орон нутгийн засаг захиргаа болон мужийн захиргаа нь нийтийн ариун цэврийн байгууламжийн эрүүл ахуй, орчны тав тух, тоног төхөөрөмжийг бүрэн хариуцан ажиллана. Үүнд:
   a. Нийтийн ариун цэврийн байгууламжийн талаар дүрэм журам гаргах;
   b. Дүрэм журмын дагуу түрээслүүлэх;
   c. Нийтийн ариун цэврийн байгууламжийн нэмэлт үйлчилгээний төлбөр авна.

88 дугаар зүйл. Нийтийн эзэмшлийн талбай:

1. Орон нутгийн засаг захиргаа болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гудамж талбай нийтийн эзэмшлийн газарт ариун цэврийн байгууламж байгуулахыг хориглоно. Хэрэв зөрчвөл таван фунт стерлингээс дээш хэмжээний мөнгөөр торгоно.
2. Орон нутгийн засаг захиргаанаас дараах шаардлагыг тавих эрхтэй. Үүнд:
   a. Зөвшөөрөгдсөн газар талбайд стандартын дагуу ариун цэврийн байгууламж байгуулах;
   b. Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, иргэдэд саад тотгор учруулахгүй байхаар байгуулах;

89 дүгээр зүйл. Үйлчилгээний байгууллагын ариун цэврийн байгууламж:

1. Орон нутгийн засаг захиргаа болон эрх бүхий байгууллагаас зочид буудал, зоогийн газар, нийтийн байр, нийтийн амралт зугаалгын газар зэрэг үйлчилгээний байгууллагуудад үйлчлүүлэгчийн тав тухыг хангасан стандартын дагуу ариун цэврийн байгууламж байгуулахыг шаардах эрхтэй.
2. Орон нутгийн засаг захиргаа болон эрх бүхий байгууллагад үйлчлүүлэгч гомдол гаргаж тухайн гомдлын дагуу ариун цэврийн байгууламжийн стандартыг хянаж шаардлага хүргүүлж шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд торгох эрхтэй байна гэж тус хуульд зааж өгсөн.

[18] Public health Act 1936 https://www.legislation.gov.uk/ukpga/Geo5and1Edw8/26/49/part/II/crossheading/public-sanitary-conveniences/enacted?view=plain

Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагааны хуулийн төсөл (A Code of Practice for Public Toilets in Britian)[19]

Хүн бүрд хүртээмжтэй эрүүл ахуйн шаардлага хангасан, орчин үеийн техник технологи ашигласан, судалгаа статистик дүн шинжилгээнд суурилсан, стандартын дагуу нийтийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэхэд зорилготой байна.

Хэрэгцээ, шаардлага

Одоогийн мөрдөгдөж байгаа BS6465 стандарт нь олон улсын ISO стандартын шаардлага хангаагүй, зарим хот, суурин газрууд нийтийн ариун цэврийн байгууламж байхгүй, эрэгтэй ариун цэврийн газар 70%, эмэгтэй ариун цэврийн газар 30% гэсэн ялгаатай харьцаатай байгаагаас дараалал үүсдэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зориулалтын тоног төхөөрөмжтэй ариун цэврийн байгууламж дутмаг, гар угаах, хүүхдийн живх солих өрөөний стандарт нь орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа нь одоогийн стандартыг шинэчлэх үндэслэл болж байна.

Дүрэм журам гаргахад анхаарах зүйл

1. Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг эрх тэгш байх;
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан байх;
3. Дараалал үүсгэхгүй байхаар зохицуулах;
4. Ариун цэврийн өрөөний доторх талбайг бүрэн дүүрэн ашиглахыг тооцоолох;
5. 24 цагаар ажиллуулах ариун цэврийн байгууламжийг байгуулах;
6. Орон нутгийн засаг захиргаа нь одоо мөрдөгдөж байгаа дүрэм журам хэр нийцтэй байгаа эрэлт хэрэгцээг судлуулах;
7. Олон нийтэд хүртээмжтэй байх, байршлын тоог нэмэгдүүлэх, байршлын тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх;
8. Ариун цэврийн байгууламжийн зураг төсөл, бүтээн байгуулалтыг шат дараалалтай төлөвлөгөөний дагуу боловсруулж, байгуулах шаардлагатай байна гэж үзсэн.

Нийтийн ариун цэврийн байгууламжид баримтлах стандарт

Ариун цэврийн байгууламжийн стандарт (Sanitary installations standart)[20]

Барилга байгууламжийн тухай хууль, Ус хангамжийн тухай хуульд үндэслэн Ариун цэврийн байгууламжийн стандарт BS6465 гаргасан.

*Тодорхойлолт- "*Орон нутгийн засаг захиргаанаас зөвшөөрөгдсөн гудамж талбай олон нийтийн эзэмшлийн газарт байгуулсан байгууламжийг нийтийн бие засах байгууламж" гэж нэрлэнэ.

Эрүүл ахуй- Нийтийн ариун цэврийн байгууламжийг байгуулахдаа цэвэрлэхэд хялбар тоног төхөөрөмжтэй, хана шаланд төхөөрөмж холбохдоо холбоосны аюулгүй байдлыг хангасан, угаалтуур, ариун цэврийн хэрэгслээр бүрэн хангана.

8 дугаар бүлэг. Ариун цэврийн өрөө

8.1- Усан хангамжийн хууль, BSEN997 стандартын дагуу бүх ариун цэврийн өрөө хуванцар суултууртай, дан болон хос ус зайлуулах сувагтай, нэг удаагийн даралтаар бохир бүрэн цэвэрлэгддэг байх ёстой.

8.1.3- Босоо тосгуурыг зөвхөн даацын хананд бэхэлнэ.

8.2.3- Хүүхдийн ариун цэврийн өрөөнд насанд нь тохирсон стандартын тосгуур байрлуулна.

---

[19] A Code of Practice for Public Toilets in Britian https://waterfund.go.ke/sanitation/Downloads/5.%20A%20Code%20of%20Practice%20for%20Public%20Toilets%20in%20Britain.pdf

[20] Sanitary installations standart BS6465-1 https://www.en-standard.eu/bs-6465-1-2006-a1-2009-sanitary-installations-code-of-practice

8.3.1- Ариун цэврийн өрөөний тосгуурын дээдэх суултуур нь ус шингэдэггүй цэвэрлэгээ хийхэд хялбар хуванцар материалаар хийгдсэн байна.
13.3.3- Нийтийн ариун цэврийн байгууламжийн хүүхдийн живх солих өрөө нь угаалтууртай, ариун цэврийн хэрэгслээр хангагдсан байх ёстой.

BS6465-1 Ариун цэврийн байгууламжийг төлөвлөх практикийн дүрэм

1дүгээр хэсэг нь хувийн орон сууц, асрамжийн газар, ажлын байр, 1000м2-аас дээш талбай бүхий дэлгүүр, худалдааны төвүүд, сургуулиуд, үзвэр үйлчилгээний газар, зочид буудал, усан сан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан байгууламжид ариун цэврийн өрөөг төлөвлөх, түүнд холбогдох хэрэгслээр хангах стандартыг зааж өгсөн.

BS6465-2 Ариун цэврийн байгууламжийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмж

2 дугаар хэсэг нь олон нийтийн байгууламжийн талбайд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг хангах, үйлчлүүлэгчийн тав тух, аюулгүй байдал, сантехникийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, хог хаягдлын бохирдлоос хамгаалах стандартыг зааж өгсөн.

BS6465-3 Ариун цэврийн байгууламжид суурилуулах тоног төхөөрөмж[21]

3 дугаар хэсэг нь олон нийтийн ариун цэврийн байгууламжид суурилуулах тоног төхөөрөмж түүний засвар үйлчилгээний стандартыг тогтоож өгсөн.

Үүнээс гадна ариун цэврийн өрөөнд суурилуулах тоног төхөөрөмж, холболт сантехникийн асуудал, техник үзүүлэлт зэрэгт тус тусад нь дагаж мөрдөх стандарт байдаг. Жишээлбэл,

BS1125- Ариун цэврийн өрөөний угаах цистернгийн техникийн үзүүлэлт
BS1189- Паалан суултуур
BS1212- Хөвөгч хавхлаг
BS1254- Ариун цэврийн өрөөний хуванцар суултуур
BS1329- Металл гар угаагч
BS1876- Бохир зайлуулах цистернгийн техникийн үзүүлэлт
BS4880- Зэвэрдэггүй ган бохир зайлуулагч
BS5503- Бидэ суултуур
BS5506- Угаалтуурын цорго
BS7357- WC угаах цистерний техник үзүүлэлт
BS7671- Цахилгааны суурилуулалт
BS6700- Дотор талбайн зохион байгуулалт зэрэг тоног төхөөрөмж, хэрэгслийн суурилуулах арга техникийг тусдаа стандартын дагуу хийнэ.

Нийтийн ариун цэврийн байгууламжийг хариуцагч байгууллага

Ариун цэврийн байгууламжийн нийгэмлэг (The British Toilet Association)[22]-нь 160 гишүүнтэй 61 нь орон нутгийн засаг захиргаанаас бүрдсэн байдаг. Тус байгууллагын чиг үүрэг:

- Нийтийн ариун цэврийн байгууламжтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах;
- Орон нутгийн засаг захиргаанаас нийтийн ариун цэврийн байгууламжийн талаарх хууль дүрэм журам гаргах хэрэгжилтийг дэмжих;
- Ариун цэврийн байгууламжийн чанар стандартад анхаарах;

[21] British Standart Sanitary installations BS6465 https://documents.pub/document/bs-6465-3-2006-sanitary-installations-selection-installation-and-maintenance
[22] The British Toilet Association http://www.btaloos.co.uk/

- Эрэгтэйчүүдийн ариун цэврийн байгууламжийн тоотой харьцуулан эмэгтэйчүүдэд ариун цэврийн байгууламжаар хангах;
- Өндөр настан, нялхас, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандартын ариун цэврийн байгууламжийн хүртээмжид анхаарах;
- Аюулгүй чанартай стандартад бүрэн нийцсэн, илүү уртасгасан цагаар ажилладаг ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлэх;
- Нийтийн ариун цэврийн байгууламжийн эвдрэл гэмтэл бүрэн бүтэн байдалд хяналт тавих;
- Нийтийн ариун цэврийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт хийдэг аж ахуй нэгжүүдэд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Холбооны гишүүдийг мэдээллээр хангах, мэдээлэл үйлчилгээ үзүүлэх;
- Бусад орны ариун цэврийн байгууламжийн холбоодтой холбоо тогтоох байна.

Одоо мөрдөгдөж байгаа стандарт болон шинэчлэх шаардлагатай тоо баримт:

Хүснэгт 2. Худалдааны төвүүд (Их Британи)

Талбайн хэмжээ	Тоног төхөөрөмж	Эрэгтэй	Эмэгтэй		Хөгжлийн бэрхшээлтэй хүн	
			Одоо байгаа	Шаардлагатай тоо	Одоо байгаа	Шаардлагатай тоо
1000-2000м2	WC	1	2	4	1	2
	Босоо тосгуур	1	-	-	-	-
	Угаалтуур	1	2	3	1	2
2001-4000м2	WC	1	4	7	1	2
	Босоо тосгуур	2	-	-	-	-
	Угаалтуур	2	4	6	1	3

Хүснэгт 3. Ажлын байр (Их Британи)

Ажилчдын тоо		Ариун цэврийн өрөөний тоо
Одоо байгаа	Шинэчлэх шаардлагатай тоо	
1-5		1
6-25	6-15	2
26-50	16-30	3
51-75	31-45	4
76-100	46-60	5
	61-75	6
	76-90	7
	91-100	8
	100 дээш	25 хүн тутам 1ш

Нийтийн ариун цэврийн байгууламжийн байршлын хувьд:

- Нийтийн тээврийн бүх зогсоол;
- Хот, муж, дүүрэг, орон нутгийн худалдааны төвүүд;
- Цэцэрлэгт хүрээлэн, спорт олон нийтийн чөлөөт цагаа өнгөрүүлэх газрууд;
- Худалдааны талбай, зах, үзэсгэлэн худалдааны газрууд;
- Хотын захын хорооллын уулзвар, шуудангийн салбаруудад;

- Оффис, үйлдвэр, худалдааны цэцэрлэгт хүрээлэн, хотоос гадуурх бүтээн байгуулалт хийж байгаа газрууд;
- 5000 гаруй хүн амтай тосгонд 3 миль тутам ариун цэврийн байгууламж байгуулах;
- Ажиллах цагийн хуваарийг уян хатан, ачаалалтай үеийг бодолцон нэмэлт ариун цэврийн байгууламж байгуулах хэрэгтэй.

Хотын хэмжээнд:

Хотын хэмжээнд макро түвшний төлөвлөгөөтэй орчин үеийн дэвшилтэт технологи ашигласан, ариун цэврийн өрөөний доторх зай стандартад нийцсэн, олон давхар барилгын давхар бүрт ариун цэврийн өрөө байх шаардлагатай. Байршлын хувьд хотын хүн ам их цуглардаг бизнес үйлчилгээний газар, автобусны буудал, төмөр замын буудал, жуулчдын ихээр очдог хотын дурсгалт газруудад байх шаардлагатай.

Дүүргийн хувьд:

Дүүрэг, орон нутгийн хэмжээнд бүх худалдааны төвүүд, автомашины зогсоол, терминалууд, барилга байшин багатай газрын төв замын дагуу зэрэгт оршин суугаа хүн амын тоонд харьцуулан ариун цэврийн газрыг байгуулах хэрэгтэй.

2.3. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

Хууль, эрх зүйн орчин

Сингапурт нийгмийн эрүүл мэндийн шаардлагуудыг хангуулахаар дэвшүүлэн гаргасан олон санаачилгын үр дүнд нийтийн бие засах газар нь хэрэглэгчдэд таатай сэтгэгдэл төрүүлж, сайн үнэлгээ авах болсон байна. Тухайлбал, нийтийн бие засах газрын үйлчилгээг хөнгөвчлөх, хэрэглэгчийн зан төлөвийг төлөвшүүлэх, ариун цэврийн өрөөг цэвэр байлгахад тусалдаг нийтийн бие засах газрын дизайны үндсэн шаардлага, шалгууруудыг хангуулах хүрээнд Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрмийг дагаж мөрддөг байна.

Харин ариун цэврийн өрөөг агааржуулалттай байлгах, шингэн саван, гар хатаагчаар хангах зэрэг үндсэн шаардлагуудыг Нийтийн бие засах газрын дизайн, үйлчилгээг сайжруулах гарын авлагаар нэмж зохицуулсан байдаг.

Сингапурын Засгийн газрын агентлагийн цахим хуудсанд ариун цэврийн өрөөг цэвэр байлгахад туслах төрөл бүрийн сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлагыг англи, хятад, энэтхэг, малай хэл дээр хэвлэн бэлтгэсэн байна. Мөн ариун цэврийн өрөөг хэрхэн хурдан, сайн цэвэрлэх сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулдаг байна.

Сингапур Улсын нийтийн бие засах газрын үйл ажиллагааг Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрэм, Нийтийн бие засах газрын дизайн, үйлчилгээг сайжруулах гарын авлагаар тус тус зохицуулж байна.

Нийтийн бие засах газрын дизайн, үйлчилгээг сайжруулах гарын авлага[23]

A Guide to Better Public Toilet Design and Maintenance

Сингапурын ариун цэврийн өрөөний холбоо[24] (Restroom Association Singapore)-ооc 2022 онд баталсан. Уг гарын авлага гурван бүлэгтэй.

Нэгдүгээр бүлэгт - ариун цэврийн өрөөний загвар (өрөөний зохион байгуулалт, гэрэлтүүлэг, материал, босоо хөтөвч, суултуур, тосгуур, тусгай хэрэгцээг дэмжсэн хэрэглэгдэхүүн, агааржуулалт, суурилуулалтын стандартууд, ухаалаг технологи).

[23] A Guide to Better Public Toilet Design and Maintenance https://www.toilet.org.sg/articles/GuideBetterPublicToilet.pdf

[24] Restroom Association of Singapore (RAS) https://toilet.org.sg/

Хоёрдугаар бүлэгт - засвар үйлчилгээ (цэвэрлэгээний дараалал, хуваарьт цэвэрлэгээ түүний давтамж, цэвэрлэх хугацаа, цэвэрлэгээний тоног төхөөрөмж, хангамж, цэвэрлэгээний бодисыг зөв хэрэглэх, цэвэрлэгээ хийх сургалт, "Happy Toilet" таних тэмдэг байрлуулах, магадлан итгэмжлэх тогтолцоо).

Гуравдугаар бүлэгт - хэрэглэгчийн боловсрол (хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөх, сургалтын зурагт хуудаснуудыг англи, хятад, энэтхэг, малай хэл дээр, олон нийтэд хүрч ажиллах тухай, нийтийн бие засах газар барих жишиг загвар, зураг төсөл) тус тус заасан байна.

Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрэм

Code of practice on environmental health-COPEH[25]

Сингапурын Байгаль орчны үндэсний агентлаг[26] (National Environment Agency) 2021 онд шинэчлэн баталсан бөгөөд Сингапурын нутаг дэвсгэр дээр барих аливаа барилга, байгууламжийн зураг төсөлд барилгын бүрдэл хэсэг болох хог хаягдлыг хадгалах, цуглуулах систем, нийтийн бие засах газар, агааржуулалт, гал тогооны яндангийн суваг, усны байгууламж, дахивар хадгалах, цуглуулах систем зэрэгт тавих стандартыг тогтоосон. Барилга, байгууламжийг барих инженер, архитекторууд нь энэ стандартыг хангаагүй бол барилга барих төлөвлөгөөг хангаагүй гэж үздэг байна.

Байгаль орчны эрүүл мэндийн практик дүрмийн 2 дугаар бүлэгт нийтийн бие засах газрын төлөвлөлтийн шаардлагыг тусгасан байна. Үүнд: нийтийн бие засах газар гэдэгт дэлгүүр, худалдааны төв, зах, зоогийн газар, кофе шоп, баар, цэнгээний газар, хурлын танхим, кино театр, автобус, тээврийн хэрэгслийн зогсоол зэргийн ариун цэврийн өрөө хамаарна. Ерөнхий шалгуурын хувьд ямар ч өнгө, загвартай байж болох бөгөөд хана, шал нь ус нэвтэрдэггүй, удаан эдэлгээтэй, гулгамтгай бус, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байна. Мөн суултуур бүр тэгш хэм бүхий кабинаар тусгаарлагдсан байх ба кабин бүр гэрэлтүүлэг, түгжээтэй, хаалга суултуур хооронд тухтай байх зайтай, харааны түвшинд эр, эм, тусгай хэрэгцээтэй гэдгийг илэрхийлсэн тэмдэгтэй байна. Эдгээрээс гадна цэвэр, бохир усны шугам, гэрэлтүүлэг, агааржуулалт, суултуур байрлуулах, ундны усны болон гар угаах цорго, шингэн саван, гар хатаагч, хогийн сав байрлуулах зэргийг заасан байна.

[25] Code of practice on environmental health
https://www.nea.gov.sg/docs/default-source/resource/practices-/copeh-2021.pdf

[26] National Environment Agency (NEA) National Environment Agency (NEA)


"Happy toilets" хөтөлбөр

"Happy Toilets" хөтөлбөрийг Сингапурын Байгаль орчны сайд асан ноён Лим Сви Сэй 2003 онд санаачилсан ба энэ нь хийц загвар, цэвэр байдал, хэрэглээ, үйлчилгээ, хэрэглэгчдийн сэтгэл ханамж гэсэн таван зарчимд төвлөрдөг санаачилга юм. Энэ хөтөлбөрийг Сингапурын ариун цэврийн өрөөний холбоо болон Байгаль орчны үндэсний агентлагаас дэмжин хэрэгжүүлдэг байна.

Сингапурын ариун цэврийн өрөөнүүдийн холбооноос тогтоосон загвар, чанар, үйлчилгээний бүх шалгуурыг хангасан шилдэг нийтийн бие засах газрууд хамгийн ихдээ зургаа хүртэлх одны үнэлгээ авах ба гурав ба түүнээс дээш одтой бүх нийтийн бие засах газруудад "Happy Toilet" таних тэмдгийг 12 сарын хугацаатай олгодог. Мөн өөрийн барилга, байгууламжийн нийтийн бие засах газарт стандартын дагуу засвар үйлчилгээ хийсэн тохиолдолд уг одыг олгож болдог байна.

Сингапурын ариун цэврийн өрөөнүүдийн холбоо цахим хуудсаараа дамжуулан "Happy Toilet" таних тэмдэг бүхий барилга байгууламжийг нийтэд сурталчлах бөгөөд ингэснээр олон нийт одтой байгууламжийг мэдэх боломжтой болдог.

Зураг 1."Happy Toilet"-ын байршлын зураг



Эх сурвалж: https://www.toilet.org.sg/loomapdirectory

2023 оны байдлаар Сингапурт "Happy Toilets" таних тэмдэг бүхий 1300 гаруй нийтийн бие засах газар байгаа ба хөл хөдөлгөөн ихтэй зах, худалдааны төв, цэцэрлэгт хүрээлэнд ихэвчлэн байрладаг ажээ.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нийтийн бие засах газруудыг стандарт, чанараар нь дараах байдлаар үнэлдэг. Эдгээрт:

1) 3 од буюу Clean Restrooms
- Ажлын нөхцөлд байгаа байгууламжууд
- Гарын саван, ариун цэврийн цаас зэрэг үндсэн хэрэгцээг хангасан
- Ямар ч үнэргүй, хоггүй
- Боломжийн хуурай шалтай
- Хэрэглэгч сэтгэл ханамжтай

2) 4 од буюу Good Restrooms
- Ажлын нөхцөлд байгаа байгууламжууд
- Гарын саван, ариун цэврийн цаас зэрэг үндсэн хэрэгцээг хангасан

- Ямар ч үнэргүй, хоггүй
- Боломжийн хуурай шалтай
- Тусгай амттан эсвэл хэрэглэгчдэд ээлтэй байгууламжтай
- Бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд нэг DFEC (Detect, Feedback, Eliminate & Clean) ухаалаг шийдлийг нэвтрүүлсэн

3) 5 од буюу Premium Restrooms
- Ажлын нөхцөлд байгаа байгууламжууд
- Гарын саван, ариун цэврийн цаас гэх мэт үндсэн хэрэгцээг хангасан
- Ямар ч үнэргүй, хоггүй
- Боломжийн хуурай шалтай
- Онцгой амттан, хэрэглэгчдэд ээлтэй эсвэл байгальд ээлтэй байгууламжтай
- Бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хоёр DFEC ухаалаг шийдлийг нэвтрүүлсэн

4) 6 од буюу Magnificent Restrooms
- Ажлын нөхцөлд байгаа байгууламжууд
- Гарын саван, ариун цэврийн цаас гэх мэт үндсэн хэрэгцээг хангасан
- Ямар ч үнэргүй, хоггүй
- Боломжийн хуурай шалтай
- Онцгой амттан, хэрэглэгчдэд ээлтэй, байгальд ээлтэй байгууламжтай
- Бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд дөрвөн DFEC-ийн ухаалаг шийдлийг нэвтрүүлсэн
- Цэвэрлэгээний ажилтнууд угаалгын өрөө цэвэрлэх чиглэлээр Сингапурын ажиллах хүчний ур чадварын (WSQ) модулийг дүүргэж, угаалгын өрөөний шалгалтын чиглэлээр Ариун цэврийн өрөөнүүдийн холбооны сургалт[27]-д хамрагдсан.
- Худалдааны төв зэрэг томоохон байгууламжууд нь зургаан одтой байх шаардлагыг хангасан байна.

Үнэлгээний шалгуур

Үнэлгээний шалгуур нь нийтийн бие засах газрын ангиллаас хамаарч өөр өөр байх бөгөөд зорилтот бүлэг бүрийн хэрэгцээг харгалзан үздэг байна. Тухайлбал, Худалдааны төвүүдийнх нь оффис, үйлдвэрээс өөр хэрэглэгчийн хэрэгцээг хангах ёстой байдаг. Гадна талбайн нийтийн бие засах газар нь төмөр зам эсвэл автобусны буудал дээр байрладаг бие засах газраас эрс ялгаатай. Ариун цэврийн өрөөг ашиглаж буй хүмүүсийн тоо, төрөл нь барилга байгууламжийг төлөвлөхөд чухал ач холбогдолтой бөгөөд "Happy Toilet" нь эдгээр бүх шалгуурыг харгалзан үздэг. Тухайлбал, хаалга дээр байрлуулах таних тэмдэг, толбогүй, хагарч цуураагүй толь, гар хатаагч, цэвэрлэгээний хуваарь, хяналт шалгалтын бүртгэл, агааржуулалт, живх солих тавцан, налуу зам зэрэг.

Үнэлгээ

Нийтийн бие засах газар бүрийг дээр дурдсан шалгуурын дагуу Сингапурын ариун цэврийн өрөөний холбооны мэргэшсэн, бие даасан төлөөлөгчид үнэлж, ерөнхий стандартыг тодорхойлдог. Дараа нь "Happy Toilet" удирдамж[28]-тай харьцуулж, стандартад хүрсэн тохиолдолд гурав, дөрөв, таван одны аль нэгийг олгодог байна.

Ийнхүү үнэлгээ хийлгэх тухай хүсэлт гаргах эрх нь Сингапурын нийтийн бие засах газрын бүх өмчлөгч, менежерүүдэд нээлттэй бөгөөд тэдний өөр өөр хэрэгцээг (худалдааны төвийн, усан сангийн, цэцэрлэгт хүрээлэнгийн ариун цэврийн өрөө г.м.) харгалзан үздэг.

[27] On-site Training Programme (OTP) on Restroom Cleaning https://toilet.org.sg/on-site-training

[28] Happy toilet programme https://www.toilet.org.sg/docs/HTPBrochure.pdf

Сингапурын ариун цэврийн өрөөний холбоо зохих хураамж төлсөн баримт, өргөдөл, маягтыг хүлээн авсны дараа үнэлгээ хийнэ. Үнэлгээ нь ариун цэврийн өрөөний хэмжээ, суултуурын тооноос хамаарч харилцан адилгүй байна.

"Happy Toilet" таних тэмдэг

Зураг 2. "Happy Toilet" таних тэмдэг



Шаардлага хангасан нийтийн бие засах газар эзэмшигчдэд ариун цэврийн өрөөний үүдэнд тавих "Happy Toilet" гэсэн таних тэмдэг бүхий самбар гардуулна. Энэ нь олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчинтэй бөгөөд уг байгууламжийг Сингапурын ариун цэврийн өрөөний холбооноос дэлхийн жишигт нийцсэн хэмээн сурталчилдаг. Аливаа байгууламж "Happy Toilet" статусаа хадгалахын тулд жил бүр дахин үнэлгээ хийлгэх шаардлагатай байдаг.

Эх сурвалж: https://www.toilet.org.sg/happytoilets

2.4. ЯПОН УЛС

Нийтийн бие засах газар нь хувийн эзэмшлийн бус ариун цэврийн өрөө (жорлон) юм. Японд хоёр төрлийн ариун цэврийн өрөө (жорлон) байдаг бөгөөд нэг нь япон, нөгөө нь барууны хэв маягтай. Япон хэв маягийн төрөл нь олон нийтийн байгууламжид ихэвчлэн харагддаг. Жишээлбэл: галт тэрэгний өртөө, их дэлгүүр, сүм дуган, дэн буудал, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт.

Зураг 3. Япон хэв маягийн (Вашики), барууны хэв маяг (Ёшики) бүхий ариун цэврийн өрөө





Хууль, эрх зүйн орчин

Ажил олгогчид ажилчдынхаа аюулгүй байдал, эрүүл мэндийг анхаарч ажиллах үүрэгтэй бөгөөд ажилчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хангах, тав тухтай ажиллах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль[29]-ийг баталсан.

Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай захирамжийг үндэслэн "Албаны эрүүл ахуйн стандарт журам", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийг (Хөдөлмөрийн яамны 1972 оны 32 дугаар тушаал) тус тус гаргасан.

[29] Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=347AC0000000057

2021 оны 12-р сарын 1-ээс бие засах газар (жорлон) суурилуулах стандартууд өөрчлөгдөж, шинэ "тусгайлсан өрөөтэй **бие засах газар**" -ыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай журам[30]-ын 628-2 т зааж өгсөн.

Тусгайлсан өрөөтэй бие засах газар нь:

- Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан тусдаа байх;
- Эрэгтэй бие засах газрын тоо нь нэгэн зэрэг ажиллаж байгаа 60 ба түүнээс доош эрэгтэй ажилтан тутамд нэг буюу түүнээс дээш байна;
- Эрэгтэй хүний бие засах газрын тоо нь нэгэн зэрэг ажиллаж байгаа 30 ба түүнээс доош эрэгтэй ажилтан тутамд нэг буюу түүнээс дээш байна;
- Эмэгтэйчүүдийн бие засах газрын тоо нь нэгэн зэрэг ажиллаж байгаа 20 эмэгтэй ажилтан тутамд нэг буюу түүнээс дээш байна;
- Ариун цэврийн цөөрөм нь хөрсөнд бохир орохоос хамгаалсан бүтэцтэй байна;
- Гар угаах байгууламжийг цэвэр урсгал усаар хангасан байх ёстой;
- Ариун цэврийн өрөө бүх талаараа ханаар хүрээлэгдсэн, хаалга нь хаагддаг, дотроосоо түгжигдэх боломжтой байх;
- Тэргэнцэртэй хүмүүст зориулсан засалт, остоматыг угаах төхөөрөмжөөр тоноглосон байх;
- Гар угаах хэрэгслийг бие засах газар суулгасан байх ёстойг заасан. Мөн бие даасан хувийн өрөөтэй жорлонгийн хувьд дараах анхаарах зүйлсийг баримталвал зохьно.
- Үнэргүй, цэвэр цэмцгэр байдлыг хадгалах ;
- Ариун цэврийн хайрцагны байдлыг анхаарах;
- Гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд гарахаас сэргийлэх;
- Яаралтай тусламжын дуудлагыг дуудах боломжоор хангах;
- Яаралтай тусламжын дуудлагын үед гаднаас нь хаалгыг онгойлгох боломжоор хангах гэх мэт.

Стандарт

Японы аж үйлдвэрийн стандартын хороо[31] (Japanese Industrial Standarts Committee-JISC)

Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамнаас байгуулагдсан зөвлөл бөгөөд Аж үйлдвэрийн стандартчиллын тухай хуульд үндэслэн үйлдвэрлэлийн стандартчиллын чиглэлээр судалгаа, хэлэлцүүлэг явуулдаг. Японы аж үйлдвэрийн стандартыг бий болгох, шинэчлэх асуудлыг хэлэлцэж, аж үйлдвэрийн стандарт, JIS тэмдгийн дэлгэцийн систем, лабораторийн бүртгэлийн систем зэрэг үйлдвэрлэлийн стандартчиллыг сурталчлах талаар холбогдох сайд нарт тавьсан санал, зөвлөгөөнд хариу өгөх, тайлан гаргах зэрэг үүрэгтэй. Түүнчлэн Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) болон Олон улсын цахилгаан техникийн комиссын (IEC) гишүүн учраас олон улсын стандартыг боловсруулахад оролцдог.

Японы аж үйлдвэрийн стандарт[32] **(Japanese Industrial Standarts-JIS)**

Тус стандарт нь эрх бүхий сайд хууль эрх зүйн журмаар баталдаг эсвэл шинэчилдэг. Нэмж дурдахад, JIS-ийг хүчин төгөлдөр болсон, шинэчилсэн өдрөөс хойш таваас доошгүй жилийн дотор хянан үзэж, эрх бүхий сайд нь JIS-ийг баталгаажуулах (байгаагаар нь хэвээр үлдээх), өөрчлөх, хүчингүй болгох ёстой. JIS батлагдах үед нэр,

[30] Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай журам https://elaws.e-gov.go.jp/document?lawid=347M50002000032
[31] Japanese Industrial Standarts Committee-JISC https://www.jisc.go.jp/jisc/index.html
[32] Japanese Industrial Standarts-JIS https://www.sanitary-net.com/trend/standard.html

дугаар, хүчин төгөлдөр болсон, шинэчлэн найруулсан, хүчин төгөлдөр болсон, шинэчлэгдсэн огноог албан ёсны сонинд зарлаж, агуулгыг вэб сайтад стандарт график хэлбэрээр байршуулдаг байна.

Японы аж үйлдвэрийн стандарт JIS нь доор үзүүлсэн шиг өвөрмөц дугаартай. Энэ тоо нь тэнхимийн кодыг илэрхийлсэн цагаан толгойн үсгийн нэг тэмдэгт болон ангиллын дугаарыг илэрхийлсэн 4 оронтой тооны хослолоос бүрдэнэ (олон улсын холбогдох стандартад нийцүүлэх үүднээс 5 ба түүнээс дээш оронтой тоонууд бас байдаг). Энэхүү өвөрмөц дугаарыг ашигласнаар техникийн нөхцөл, гэрээ гэх мэт стандарт нэрийг заахгүйгээр гүйлгээ, худалдан авалт хийх боломжтой.

Жишээ: JIS G 3112 Төмөр бетонд зориулсан ган баар

* Цагаан толгойн G үсэг нь (ган) ангиллыг илэрхийлдэг.

Ариун цэврийн өрөөтэй холбогдол бүхий зарим стандартаас дурдвал:

- JIS A 5207:2022 Ариун цэврийн хэрэгсэл - Суултуур, угаалтуур (Зохиогч байгууллага: Японы ариун цэврийн өрөөний аж үйлдвэрийн холбоо)
- JIS A 4422:2011 халуун усаар угаадаг суудал (Зохиогч байгууллага: Японы ариун цэврийн өрөөний аж үйлдвэрийн холбоо)
- JIS C 9335-2-84:2019 Ахуйн болон түүнтэй адилтгах цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал-2-84-р хэсэг: Ариун цэврийн хэрэгсэлд тавигдах тусгай шаардлага (Зохиогч байгууллага: Японы стандартын холбоо, Японы ариун цэврийн өрөөний аж үйлдвэрийн холбоо)
- JIS S 0026:2007 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан заавар-Нийтийн бие засах газар дахь жорлонгийн үйл ажиллагааны хэсгүүдийн хэлбэр, өнгө, зохион байгуулалт (жорлонгийн ус зайлуулах товчлуур ба дуудлагын товчлуур), тоног төхөөрөмжийн зохион байгуулалт (Японы стандартын холбоо, Нийтлэг барааг дэмжих байгууллага) гэх мэт.

International Organization for Standardization-ISO[33] гэдэг нь Швейцарийн Женев хотод төвтэй төрийн бус байгууллага болох Олон улсын стандартчиллын байгууллагын (ОУСБ) товчлол юм. ОУСБ-ын үндсэн үйл ажиллагаа нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг бий болгох явдал бөгөөд ISO-аас тогтоосон стандартуудыг ISO стандарт гэж нэрлэдэг. ISO стандартууд нь олон улсын гүйлгээг хөнгөвчлөх зорилгоор “дэлхий даяар ижил чанартай, ижил түвшинд бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх боломжийг олгодог” олон улсын стандарт юм.

Ариун цэврийн өрөөтэй холбогдол бүхий зарим стандартаас дурдвал:

- ISO 19026: 2015 Хүртээмжтэй дизайн Нийтийн ариун цэврийн өрөөний ханан дээрх угаах товчлуур болон дуудлагын товчлуурын хэлбэр, өнгө, тэдгээрийн байршил, түүний дотор цаас өнхрөх. ISO 19026 стандарт нь Японы JIS S 0026:2007 (Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан загвар зохион бүтээх заавар - нийтийн бие засах газрын хэлбэр, өнгө, жорлонгийн үйл ажиллагааны нэгжийн зохион байгуулалт (жорлонг угаах товчлуур ба дуудлагын товчлуур), зохион байгуулалт дээр үндэслэсэн болно. Энэхүү олон улсын стандартыг дараах асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор боловсруулсан болно.

    - Ариун цэврийн өрөөнд ихэвчлэн ганцаараа ордог тул ойлгохгүй байгаа эсэхийг бусдаас асуух боломжгүй. Харааны бэрхшээлтэй иргэд ариун цэврийн өрөөнд орохдоо хананд гараараа хүрч, тоног төхөөрөмжийн зохион байгуулалт, ямар

[33] International Organization for Standardization-ISO https://www.iso.org/home.html


төрлийг нь урьдчилан баталгаажуулах шаардлагатай байдаг бөгөөд энэ нь шаардлагатай хэмжээнээс илүү цаг хугацаа, хүчин чармайлт шаарддаг.

- Угаах товчлуур болон цаасны өнхрүүлгийн байршил нь тэдний үйл ажиллагааны онцлогтой таарахгүй байж болзошгүй тул бие махбодийн хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчид бүтээгдэхүүнийг ашиглахад хэцүү эсвэл боломжгүй байж магадгүй юм.

Зураг 4. Харааны бэрхшээлтэй хэрэглэгчдийн товчлуур (Япон)



Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчдэд зориулсан товчлуурын ажиллагаа




Асуудлуудыг шийдвэрлэх дараахь стандартыг тогтоосон:

- Ариун цэврийн өрөөний хажуугийн хананд цаасан өнхрөх, угаах товчлуур, дуудлагын товчлуурыг бие махбодийн бэрхшээлтэй хэрэглэгчдэд бие засах газар дээр сууж байхдаа хүрэх боломжтой газарт суурилуулсан;
- Угаах товчлуурыг хайрцагны дээд талд байрлуулсан бөгөөд дуудлагын товчлуур нь угаах товчлууртай ижил өндөрт, ард нь хэвтээ байрлалтай байдаг тул харааны бэрхшээлтэй хүмүүс хүрэхэд хялбархан байршлыг нь олох боломжтой;

- Товчлуурын хэлбэр, өнгийг тодорхойлсноор харааны бэрхшээлтэй хэрэглэгчид угаах болон дуудлагын товчлуурыг мэдрэгчтэйгээр ялгаж чаддаг.

Зураг 6. Японы Ариун цэврийн өрөөний аж үйлдвэрийн холбооноос Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны "Нийтийн ариун цэврийн өрөөнд угаах товчлуурыг байрлуулах олон улсын стандарт гаргасан"-д үндэслэн гаргасан.



Сүүлийн жилүүдэд халуун устай ариун цэврийн өрөөний суултуур дэлхий даяар тархаж, даяаршил хөгжиж байгаа тул үнэлгээний зохих аргуудыг стандартчилах эрэлт хэрэгцээ их байна. Ийм нөхцөлд олон улсын стандартыг (IEC 62947) бүлээн усны бидэтэй жорлонгийн суултуурын олон улсын гүйцэтгэлийн үнэлгээний "дүрэм" болгон бүртгэсэн. Үүний үр дүнд хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ сонгоход нь туслах зорилгоор туршилтын үр дүнг ил тод болгох боломжтой болох бөгөөд энэ нь өрсөлдөөнийг бүрдүүлж, халуун устай жорлонгийн суултуурын зах зээлийг нээнэ гэж үзэж байна.

Зураг 7. Бидэ (халуун устай бүлээн суултуур) бүхий барууний хэв маяг бүхий ариун цэврийн өрөө



Холбогдох байгууллага

Японы ариун цэврийн өрөөний нийгэмлэг[34] (Japan Toilet Association-JTA)

[34] Japan Toilet Association-JTA https://j-toilet.com/english/

Тус нийгэмлэг нь 1985 онд архитектор, дизайнар, байгаль орчны судлаачид, эмч нар, бизнес эрхлэгч нар хамтран байгуулсан сайн дурын байгууллага юм. Тус байгууллага нь бие засах газруудыг судалж, хамгийн сайн орчинг бүрдүүлэх зорилготойгоор сургууль, уул, голын эрэг, эмнэлгийн тусламж үйлчилгээ, гамшиг ослын газар, үзэсгэлэнт газруудын соёлыг төлөвшүүлэх зорилготойгоор нийгэм, нийтээрээ хөдөлж байх үед байгууллагдсан, нийтийн ариун цэврийн өрөөнд нухацтай ханддаг дэлхийн анхны байгууллага хэмээн олонд танигдсан. Японы ариун цэврийн өрөөний нийгэмлэгийн үйл ажиллагаанд Нийтийн ариун цэврийн өрөөний өдөрийг тэмдэглэх, японы өнцөг булан бүрээс судалгааны материалуудыг цуглуулах, тайлан гаргах, орон нутгийн засаг захиргаанд зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах зэрэг орно. 2009 онд тус нийгэмлэгийн нэгэн хэсэг болох хүүхдийн ариун цэврийн өрөөний орчныг сайжруулах хөдөлгөөнийг зохион байгуулж байсан хэлтэс нь Японы ариун цэврийн өрөө судлалын хүрээлэн болж бие даан үйл ажиллагаа явуулахаар болсон.

Японы ариун цэврийн өрөө судлалын хүрээлэн[35] (Japan Toilet Labo-JTA)

Энэ хүрээлэн нь ариун цэврийн байгууламжаар дамжуулан нийгмийг илүү сайнаар өөрчлөх үзэл баримтлалтай ажилладаг ашгийн бус байгууллага юм. Ариун цэврийн өрөөнд хүн бүр байгаль орчин, соёл боловсрол, эрүүл мэндээ бодож бие засдаг, амар тайван амьдрах нийгмийг бий болгох зорилготойгоор дараах үйл ажиллагааны бодлогыг баримталдаг. Үүнд:

1. Хүүхдийн бие засах газар, эрүүл ахуйн боловсрол олгох замаар эрүүл мэндийг дэмжих, эрүүл амьдрах орчныг бүрдүүлэх;
2. Нийтийн бие засах газрын хувьсал, ариун цэврийн өрөөний бизнесийг бий болгосноор аюулгүй амьдрахад таатай нийгэм бий болгох;
3. Хог хаягдлыг дахин боловсруулж, байгальд ээлтэй ариун цэврийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар экологийн нийгмийг бий болгохыг зорих;
4. Гамшгийн үед бие засах арга хэмжээг сурталчлах;
5. Ариун цэврийн болон усны орчныг сайжруулах замаар дэлхийн дулаарлаас урьдчилан сэргийлэх үйл ажил тус тус орно.

2.5. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Солонгос улсад сүүлийн 40 орчим жилийн хугацаанд нийтийн ариун цэврийн байгууламжийн хангамж, менежмент, соёл хурдацтай хөгжсөн гэж үздэг. Ийнхүү хөгжихөд төрийн бодлого, үйл ажиллагаа, оролцоо болон төсөв санхүүгийн хөрөнгө оруулалт, төр-хувийн хэвшлийн түншлэл болон иргэдийн дэмжлэг хамгийн их нөлөө үзүүлжээ. Тус улсын нийтийн ариун цэврийн өрөөний түүхийг авч үзвэл, хамгийн анхны орчин үеийн нийтийн ариун цэврийн өрөөг 1857 онд суурилуулж байсан бол 1956 онд анхны төлбөртэй ариун цэврийн өрөө бий болжээ. Харин орчин үеийн нийтийн ариун цэврийн байгууламжийн хөгжил, сайжруулах үйл явцыг гурван үед хуваан авч үздэг байна[36]. Тухайлбал,

- **Нэг дэх үе буюу ариун цэврийн өрөөний хувьсгал:** 1986 оны Азийн наадам, 1988 оны Олимпийн наадмыг амжилттай зохион байгуулах хүрээнд ариун цэврийн өрөөний эрс өөрчлөлт, ерөнхий сайжруулалт хийгдсэн. Энэ үед нийтийн ариун цэврийн өрөөний тоог нэмэгдүүлэх, дэд бүтцийн асуудлыг цогцоор нь шийдэх богино/урт хугацааны төлөвлөгөө гаргаж амжилттай ажилласан.

[35] Japan Toilet Labo-https://www.toilet.or.jp/about/

[36] Korean public toilet improvement experience and its implications https://archives.kdischool.ac.kr/bitstream/11125/42118/1/%282014%29%20Modularization%20of%20Korea%27s%20development%20experience_Korean%20public%20toilet%20improvement%20experience%20and%20its%20implications.PDF

- **Хоёр дахь үе буюу үзэсгэлэнт ариун цэврийн өрөө** (Beautiful Toilet): 1990 оны сүүлчээс 2000-аад оны эхэн үе хүртэл 2002 оны хөлбөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл ажлын хүрээнд нийтийн бие засах газрын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг эерэгээр өөрчлөхөд анхаарлаа хандуулсан шинэчлэл хамаарна. Энэ үед төв болон орон нутгийн засаг захиргаанаас ариун цэврийн байгууламжийг бүрэн шинэчлэх төсвийг эрс нэмэгдүүлж, хамтран ажиллажээ.
- **Гурав дахь үе буюу "Ногоон ариун цэврийн өрөө":** 2000 оны сүүлээс Үзэсгэлэнт ариун цэврийн өрөө төслийн хүрээнд "Ногоон ариун цэврийн өрөө" төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ нь байгаль орчинд ээлтэй, эрчим хүч хэмнэсэн, хэрэглэхэд тохиромжтой ариун цэврийн өрөө гэж тодорхойлсон. Энэ хүрээнд 2011 оноос хойш нийтийн ариун цэврийн байгууламжид дахин боловсруулсан усыг ашиглах төслийг хэрэгжүүлж эхэлжээ.

2004 онд Нийтийн ариун цэврийн байгууламжийн хуулийг баталж, нийтийн ариун цэврийн байгууламжтай холбоотой харилцааг удирдан зохион байгуулах үүргийг Дотоод хэрэг, аюулгүй байдлын яаманд харьяалуулж, хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг бүрдүүлэх, орон нутгийн засаг захиргаанд нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах зардлыг дэмжих, удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэгтэй болсон. Түүнчлэн орон нутгийн засаг захиргаанаас санал болгосны дагуу нийтийн ариун цэврийн байгууламж барих төвлөрсөн үнэлгээг жил бүр улсын хэмжээнд хийдэг болжээ.

Нийтийн ариун цэврийн байгууламжтай холбоотой харилцааг 2004 онд батлагдсан Нийтийн ариун цэврийн байгууламжийн хуулиар зохицуулж байна. Түүнчлэн Усан хангамж, усан байгууламж суурилуулах тухай хууль (Water supply and waterworks installation act, 1964)[37], Ариутгах татуургын тухай хууль (Sewegare act, 1973)[38], Барилгын тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоол (Enforcement decree of the building act, 1982)[39] болон Ерөнхийлөгч, хотын захиргаанаас баталсан журам, стандартуудыг дагаж мөрддөг байна. Тухайлбал, Нийтийн ариун цэврийн байгууламжийн хууль зааснаар Ерөнхийлөгч Хүүхдэд зориулсан тосгуур, суултуур суурилуулах стандарт, Нярай, бага насны хүүхдийн живх солих ширээний стандарт, Нийтийн ариун цэврийн байгууламжийн менежментийн стандартыг, Хот/муж/дүүргийн дарга Хөдөлгөөнт ариун цэврийн байгууламж суурилуулах, зохион байгуулах стандартыг тус тус батлан мөрдүүлнэ.

Ариун цэврийн байгууламжийн талаарх зохицуулалтыг анх 1982 оны Барилгын тухай хуульд хийсэн байдаг бөгөөд байгалийн гэрэлтүүлэг, агааржуулалтын цонхийг ариун цэврийн өрөөнд суурилуулахаар, мөн эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө тусдаа байх зохицуулалт байжээ. Нийтийн ариун цэврийн байгууламжийн хуулийн дагуу бүх төрийн байгууллагын ариун цэврийн өрөө нийтэд нээлттэй байдаг бөгөөд нийтийн бие засах газрын 70 орчим хувийг эзэлдэг байна. Үүний дараа 10 орчим хувийг цэцэрлэгт хүрээлэнгийн нийтийн ариун цэврийн байгууламж эзэлдэг байна.

Нийтийн ариун цэврийн байгууламжийн хууль (Public toilets act): Хуулийн зорилго нь нийтийн бие засах газрыг байгуулах, ашиглах, түүний эрүүл ахуйтай холбоотой харилцааг тодорхойлж, олон нийтэд эрүүл ахуйн ая тухтай, сайн сайхан байдлыг сурталчилахад хувь нэмэр оруулах юм. Энэхүү хууль нь 2004 онд батлагдсан, 22 зүйлтэй.

[37] Water supply and waterworks installation act https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=60267
[38] Sewegare act https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?lang=ENG&hseq=60964
[39] Enforcement decree of the building act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=51319&type=sogan&key=4

Тус хуульд нийтийн ариун цэврийн өрөөг дараах төрөлтэй байхаар тодорхойлжээ. Тухайлбал,

- Нийтийн ариун цэврийн өрөө (Public toilet)
- Нийтийн хэрэгцээний ариун цэврийн өрөө (toilet for public use)
- Хөдөлгөөнт ариун цэврийн өрөө (movable toilet)
- Зөөврийн ариун цэврийн өрөө (portable toilet)
- Төлбөртэй ариун цэврийн өрөө (pay toilet)

Нийтийн ариун цэврийн өрөө гэж төр, орон нутгийн засаг захиргаа, байгууллага болон хувь хүмүүсээс нийтийн хэрэгцээнд зориулан суурилуулсан ариун цэврийн өрөөг ойлгоно. Нийтийн ариун цэврийн өрөө, байгууламжийг эзэмшиж, удирдаж байгаа эрх бүхий этгээд нь тухайн байгууламжийг удирдах хүн (нийтийн ариун цэврийн өрөөний менежер "public toilet manager")-ийг томилж, Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам (Ministry of the Interior and Safety)-ны шийдвэрээр түүнд хяналт тавина. Менежер нь нийтийн ариун цэврийн байгууламж болон түүний эргэн тойрны менежментийг стандартад заасны дагуу удирдан зохион байгуулна.

Нийтийн хэрэгцээний ариун цэврийн өрөө гэж төрийн байгууллагын байгууламжид суурилуулсан ариун цэврийн өрөөний дунд нийтийн хэрэгцээнд нээлттэй ариун цэврийн өрөө, өөрийгөө удирдах тусгай хот, мужийн захирагч болон хот/муж/дүүргийн даргын тогтоосон нийтийн ариун цэврийн өрөөг ойлгоно.

Төрийн байгууллагын дарга нь дор дурдсанаас бусад тохиолдолд тухайн барилга, байгууламжид суурилуулсан ариун цэврийн өрөөг нийтийн хэрэгцээнд ашиглуулна. Тухайлбал,

- Тухайн байгууламж, үйл ажиллагааны онцлогийг харгалзан олон нийт нэвтрэх боломжгүй;
- Тухайн барилга, байгууламжийн бүтцийн онцлогоос шалтгаалж нийтийн ариун цэврийн өрөө суурилуулах боломжгүй.

Хөдөлгөөнт ариун цэврийн өрөө гэж томоохон арга хэмжээ, цугларалтад ашиглахаар суурилуулсан нийтийн ариун цэврийн өрөөг ойлгоно. Хот/муж/дүүргийн дарга өөрийн харьяалах нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж буй олон тооны хүн цугларах арга хэмжээнд хөдөлгөөнт ариун цэврийн өрөө суурилуулахыг тухайн арга хэмжээг зохион байгуулагчдаас шаардах эрхтэй. Энэхүү шаардлагыг биелүүлээгүй бол нэг сая воноос хэтрэхгүй хэмжээний торгууль ногдуулна.

Зөөврийн ариун цэврийн өрөө гэж нийтийн ариун цэврийн өрөө суурилуулах боломжгүй газарт суурилуулсан жижиг ариун цэврийн өрөөг ойлгоно. Хот/муж/дүүргийн дарга цахилгаан, усан хангамж, бохир ус гэх мэт нийтийн ариун цэврийн байгууламж суурилуулах боломжгүй уул, далайн эрэг, голын эрэг зэрэг газарт зөөврийн ариун цэврийн өрөөг суурилуулж болно. Энэ тохиолдолд аадар бороо, шуурганы улмаас хүрээлэн буй орчинг бохирдуулахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авсан байна.

Төлбөртэй ариун цэврийн өрөө гэж суурилуулагч эсхүл менежер нь хэрэглэгчдээс төлбөр авах боломжтой ариун цэврийн өрөөг ойлгоно. Төлбөртэй ариун цэврийн өрөө суурилуулах, ажиллуулахаар төлөвлөж буй аж ахуй нэгж, хувь хүн хот/муж/дүүргийн даргад хүсэлтээ хүргүүлнэ. Хот/муж/дүүргийн дарга хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор шийдвэр гаргана. Хэрэв 10 хоногийн дараа сунгах талаар мэдэгдээгүй бол дараагийн өдөр нь хүсэлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Үүний дараа төлбөртэй ариуйн цэврийн өрөө суурилуулсан болон ажиллуулж буй этгээд 15 хоногийн дотор олон нийтийн нүдэнд харагдахуйц газарт төлбөртэй ариун цэврийн өрөөг илэрхийлсэн зарын самбарыг байршуулна.

Нийтийн ариун цэврийн байгууламжийн хуульд зааснаар дараах байгууламж дахь ариун цэврийн өрөө нийтийнх байна. Үүнд:

- Байгалийн цогцолборт газар;
- Аялал жуулчлалын газар, цогцолбор, туслах байгууламжийн дунд;
- Автобусны буудлууд;
- Дэлгүүр, түр зах, худалдааны төв, төрөлжсөн худалдааны цогцолбор;
- Хотын цэцэрлэгт хүрээлэн;
- Авто замын амралтын байгууламж;
- Төмөр замын байгууламжийн дундах өртөөний байгууламж;
- Хотын төмөр замын байгууламжийн дундах өртөө, байгууламж;
- Боомт дахь зорчигчийн байгууламж;
- Аялал жуулчлалын хөлөг онгоц, гатлага онгоц;
- Шатахуун түгээх станц;
- Шингэрүүлсэн шатдаг хий дүүргэх үйл ажиллагаа эрхэлдэг цэнэглэх станцууд;
- Спортын байгууламж;
- Нисэх онгоцны буудлын байгууламж;
- Олон нийтийн тоглолт хийх газар;
- Төрийн болон орон нутгийн засаг захиргаанаас олон нийтийн хэрэгцээнд зориулан суурилуулсан байгууламж;
- Аж ахуй нэгж, хувь хүний эзэмшиж, олон хүн ашигладаг, цар хүрээ нь хууль тогтоомжоор тогтоосон хэмжээнээс давсан бусад байгууламж.

Төрийн болон орон нутгийн засаг захиргаа нь ариун цэврийн байгууламжийн түвшинг дээшлүүлэхийн тулд нийтийн хэрэгцээнд зориулсан нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах, зохион байгуулах, зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг боловсруулна. Харин хот/муж/дүүргийн дарга нь өөрийн харьяалах нутаг дэвсгэр дэх нийтийн ариун цэврийн байгууламж суурилуулах, нийтэд нээлттэй ариун цэврийн өрөөний эрэлт, нийлүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулна.

Нийтийн ариун цэврийн өрөө нь эрэгтэй, эмэгтэй гэж ялгасан байх ёстой бөгөөд эмэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөний суултуур нь эрэгтэй ариун цэврийн өрөөний суултуурын тооноос дор хаяж 1.5 дахин их байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан суултуурыг стандартын дагуу суурилуулна. Түүнчлэн хүүхдийн суултуур, угаалтуур суурилуулах бөгөөд нярай, бага насны хүүхдийн живх солих ширээг эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөнд байрлуулах шаардлагатай.

Ариун цэврийн байгууламжийн арчилгаа, зохион байгуулалтын талаарх хяналт шалгалтыг хот/муж/дүүргийн дарга жил бүр тогтмол хийх бөгөөд ариун цэврийн байгууламжийн суурилуулах стандарт, удирдлагын стандартыг зөрчсөн бол сайжруулах, хаах, нураах шийдвэр гаргаж болох бөгөөд шаардлагыг биелүүлээгүй этгээдэд нэг сая воноос хэтрэхгүй хэмжээний торгууль ногдуулна.

Нийтийн ариун цэврийн байгууламжийг ашиглаж буй хүн дараах үйлдэл хийхийг хориглох бөгөөд зөрчсөн этгээдэд таван зуун мянган воноос хэтрэхгүй торгууль ногдуулна. Үүнд:

- Нийтийн ариун цэврийн өрөөг сараачих;
- Нийтийн ариун цэврийн өрөөний эд зүйлсийг гэмтээх;
- Ашгийн төлөө зар сурталчилгаа наах, байршуулах;
- Нийтийн ариун цэврийн өрөөнд хог хаягдал үлдээх гэх мэт.

Нийтийн ариун цэврийн байгууламжийн хуульд хот/муж/дүүргийн даргын эрх, үүргийг тодорхойлж өгснөөс гадна түүнтэй зөвшилцөх, нийтийн ариун цэврийн

байгууламжтай холбоотой асуудлыг хариуцах дараах хоёр байгууллага байхаар заасан байна. Үүнд:

- Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа хариуцсан зөвлөх хороо (Advisory Committee Members for Operation of Public Toilets);
- Солонгосын ариун цэврийн байгууламжийн нийгэмлэг (The Korea Toilet Association).

Төрийн болон орон нутгийн засаг захиргаа нийтийн ариун цэврийн байгууламж суурилуулах, удирдан зохион байгуулах, сайжруулахад шаардлагатай зарим зардлыг төсвийн хязгаарт багтаан гаргаж болно. Хот/муж/дүүргийн даргын шийдвэр (захирамж)-ээр харьяалах нийтийн ариун цэврийн байгууламжийн удирдах ажлыг хувь хүн, байгууллагаар удирдуулж болно.

Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа хариуцсан зөвлөх хороо

Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа хариуцсан зөвлөх хороог хот/муж/дүүрэгт байгуулж, нийтийн ариун цэврийн байгууламжийг суурилуулах, зохион байгуулах, зохион байгуулалттай холбоотой дараах асуудлаар хот/муж/дүүргийн даргатай зөвлөлдөнө. Үүнд:

- Нийтийн ариун цэврийн байгууламжийн эрэлт нийлүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах;
- Нийтийн ариун цэврийн байгууламж суурилуулах, эсхүл нийтийн хэрэгцээнд зориулсан ариун цэврийн өрөөг тодорхойлох;
- Төлбөртэй, хөдлөх болон зөөврийн ариун цэврийн өрөө суурилуулахай холбоотой асуудал;
- Нийтийн ариун цэврийн байгууламжийн үйл ажиллагаа, зохион байгуулалтад шаардлагатай бусад асуудал.

Солонгосын ариун цэврийн байгууламж нийгэмлэг

Ариун цэврийн байгууламжтай холбоотой бизнес эрхэлдэг хүмүүс, судалгаа, сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүс болон Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад хүмүүс ариун цэврийн байгууламжтай холбоотой судалгаа шинжилгээ, техник технологийн хөгжил, ариун цэврийн соёлыг зөв төлөвшүүлэх зорилгоор Солонгосын ариун цэврийн байгууламжийн нийгэмлэгийг байгуулж болохоор хуульчилсан. Нийгэмлэгийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай зардлыг гишүүдийн татвар, түүний дотор ариун цэврийн байгууламж, бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлого болон төр, орон нутгийн засаг захиргааны төсвийн хязгаарт багтаан олгосон төлбөрөөр санхүүждэг.

2.6. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Дэлхийн Ариун Цэврийн Өрөөний Байгууллага нь эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулах болон ариун цэврийн өрөөний байгууламжаар нийтийг хангах үндсэн зорилгын дор 2001 онд байгуулагдаж, ариун цэврийн өрөөний дэлхийн чуулганыг зарлан хуралдуулсан байна. 2019 оны байдлаар, дэлхийн хэмжээнд 10 хүн тутмын 6 шахам нь буюу нийт 2.5 тэрбум гаруй хүн эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөгөөр хангагдах боломжгүй байна.[40]

[40] Жорлон-Toilette-*германаар* https://de.wikipedia.org/wiki/Toilette

Европын холбооны Хүний эрхийн конвенцийн 3 дахь заалт, Германы Үндсэн хуулийн 1 ба 2 дахь заалтын дагуу хэн ч ялангуяа төрийн эрх хэрэгжүүлэгч ч байлаа гэсэн бие засах зорилгоор ариун цэврийн өрөө ашиглахад нь хэнд ч саад учруулж үл болно.[41]

ХБНГУ-д нийтийн хоолны газрын эрх зүй нь муж улсын түвшинд хамаарах тул ариун цэврийн өрөө (АЦӨ)-ний үүргийн талаар нэгдсэн ерөнхий зохицуулалт байхгүй учир муж улс бүрт тавигдах шаардлага, нөхцөл нь ялгаатай байдаг байна. Гэвч барилга, хот байгуулалт болон аж ахуын нэгжийн улсын бүртгэлийн алба нь нэгдмэл хуулийн зохицуулалтгүй ч гэлээ нийтийн АЦӨ-ний үүргийг заавал шаарддаг байна.

Харин АЦӨ-ний тоо нь зочин хүлээн авах талбай болон ямар төрлийн ундаагаар үйлчлэхээс хамаардаг байна. Хэрэв зочны талбайн багтаамж 200 хүнээс дээш бол уг газрыг арга хэмжээ зохион байгуулдаг газар гэж үзнэ. Энэ тохиолдолд АЦӨ-ний үүргийг хуулиар тогтоосон байдаг байна.

Хэрэв нийтийн хоолны газар нь хоол идэж, ундаа уух зориулалтын ширээгүй зөвхөн авч явах зориулалтын заал бүхий 50 м^2 хүрэхгүй үйлчилгээний талбайтай, зөвхөн алкохолгүй ундаагаар үйлчилдэг бол АЦӨ-ний үүргээс чөлөөлөгддөг байна.

Хүснэгт 4. Нийтийн хоолны газарт байх АЦӨ-ний тоо

№	Үйлчилгээний талбай [м^2]	АЦӨ-ний тоо
1	<50	1
2	50-100	2 эмэгтэй, 1 эрэгтэй, 3 шээсний босоо буюу 2.0 м урт ховил
3	100-150	2 эмэгтэй, 2 эрэгтэй, 3 шээсний босоо буюу 2.5 м урт ховил
4	150-200	3 эмэгтэй, 2 эрэгтэй, 4 шээсний босоо буюу 3.0 м урт ховил
5	200-250	3 эмэгтэй, 2 эрэгтэй, 5 шээсний босоо буюу 3.5 м урт ховил
6	250-350	4 эмэгтэй, 3 эрэгтэй, 6 шээсний босоо буюу 4.0 м урт ховил
7	>400	Тусгайлан тогтооно

Жич: *АЦӨ-ний тооноос үл хамааран тухай бүрт салангид угаалгын хэсэг байвал зохино.*

Нийтийн хоолны газрын тусгай зөвшөөрөл олгохдоо саадгүй АЦӨ буюу хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан АЦӨ-тэй байх шаардлагыг ерөнхийдөө нэгдмэл байдалтай тусгасан байна. Энэхүү зохицуулалт нь 2002.11.01-ний өдрөөс хойш барилгын зөвшөөрлөө авсан буюу 2002.05.01-нээс хойш барилгын зөвшөөрөл авалгүй өөрчилсөн болон өргөтгөсөн барилгад хамаарна.

Зочин бус хүнд АЦӨ-гөөр үйлчлэх, хэрэв үйлчилбэл хураамж авах эсэх нь уг нийтийн хоолны газрын эзэмшигчийн эрх байдаг байна. Харин зочноос хураамж авах эсэх нь муж улсуудад ялгаатай байдаг байна. Гэвч төлбөрөө хийсэн үйлчлүүлэгчээс хураамж авахгүй байх нь сайн үйлчилгээнд тооцогдох болно.[42]

Ажлын байран дахь АЦӨ болон бусад эрүүл ахуйн өрөөнд тавигдах нөхцөл, шаардлага, хэв журмыг Холбооны Улсын түвшинд Ажлын байрны дүрмээр тогтоон журамласан байна.

Хууль тогтоогчийн хувьд, АЦӨ гэж дор хаяхад нэг суултуур, нэг угаалтуур, мөн зарим тохиолдолд нэг шээлтүүр бүхий өрөөг хэлнэ. Барилгын хийц талаас нь харвал, АЦӨ гэж суултуур бүхий үүр, мөн ханаар тусгаарлагдсан **дотроосоо түгжих** боломжтой **суултуур**, эсвэл гар угаах зориулалтын тосгуур бүхий угаалтууртай нэг үүдний өрөө бүхий түгжих

[41] Сургуулийн эрх зүй: Сургуульд АЦӨ орохыг хориглох нь үндэстэй юу?-Schulrecht - Toilettenverbot an der Schule rechtsmäßig?-*германаар* https://www.anwalt.de/rechtstipps/schulrecht-toilettenverbot-an-der-schule-rechtsmaessig_060575.html#:~:text=Jedermann%20hat%20das%20Recht%2C%20nicht,2%20GG%20(Grundgesetz)%20abgesichert.

[42] Нийтийн хоолны академи-Gastro academy-*германаар* https://www.gastro-academy.com/gruenden/gesetze-vorschriften/toilettenpflicht/#:~:text=Betriebe%2C%20in%20denen%20Alkohol%20ausgeschenkt,50%20Sitzpl%C3%A4tze%20f%C3%BCr%20G%C3%A4ste%20bieten.

боомжтой жижиг өрөөнүүдийг хэлнэ. Ажил олгогч нь бодит ажлын байр, хувцас солих, завсарлагын зориулалттай өрөө тасалгаа буюу шүршүүр, угаалгын өрөөний ойролцоо суултуур бэлэн байлгах үүрэгтэй байна. 9-ээс дээш ажилтантай бол АЦӨ-нүүдийг хүйсээр (эрэгтэй, эмэгтэй) ялгаатай тусад нь байлгах үүрэгтэй байна. 9-ээс цөөн ажилтантай бол нэг суултуур байхыг зөвшөөрдөг байна.

Ажлын байрны дүрэмд тусгагдсанаар АЦӨ-нд тавигдах шаардлага:

- Ажлын байр, завсарлагын өрөө болон угаалгын буюу шүршүүрийн өрөөнөөс хурдан, амар **хүрэх** боломжтой байх;
- АЦӨ-г дотроос ямагт **түгжих** боломжтой байх;
- АЦӨ-ний **үзэгдэх орчинг хаасан** байх;
- Энэхүү эрүүл ахуйн байгууламжийг ашиглах ажилтнуудын **тоонд** зохицсон байх;
- Ажлын байрнаас 5-100 метрээс холгүй байх;
- Ажлын байртай нэг байшинд, нэг давхраас холгүй байх;
- **Суултуур** болон/буюу **АЦӨ** гэсэн тэмдэглэгээтэй байх.

Ажлын байрны дүрэмд дараах үндсэн чиглэлийг тусгасан байна. Үүнд:

- АЦӨ нь ажилтан саад бэрхшээлгүй ашиглах боломжтой **талбайтай** байвал зохино.
- **Халуун, хүйтэн** урсгал усаар хангана.
- **Угаалгын бодис** болон **гарын алчуур** буюу гар **хатаах тоноглол** байрлуулна.
- Эрүүл мэндийн байгууламж зэрэг онцгой хэсэгт **ариутгалын бодис** байвал зохино.

Түүнээс гадна таазны өндөр 2.50 м-ээс багагүй байх ба хөдөлгөөнд саад учруулахгүй үүднээс АЦӨ-ний үүрний хэмжээ ойролцоогоор 60х80 см байвал зохино.[43]

Хүснэгт 5. Ажлын байранд байх АЦӨ-ний тоо

№	Ажилтны тоо	Суултуур, шээлтүүр, гар угаалтуурын тоо
1	<5	1 суултуур+1 шээлтүүр (зөвлөмж)+1 угаалтуур
2	6-10	1 суултуур+1 шээлтүүр (зөвлөмж)+1 угаалтуур
3	11-25	2 суултуур+1 угаалтуур
4	26-50	3 суултуур+1 угаалтуур
5	51-75	5 суултуур+2 угаалтуур
6	76-100	6 суултуур+2 угаалтуур
7	101-130	7 суултуур+3 угаалтуур
8	131-160	8 суултуур+3 угаалтуур
9	161-190	9 суултуур+3 угаалтуур
10	191-220	10 суултуур+4 угаалтуур
11	221-250	11 суултуур+4 угаалтуур

[43] Ажлын байрны дүрэм: АЦӨ болон бусад эрүүл ахуйн өрөөнд тавигдах ажлын байрны шаардлага, нөхцөл-Arbeitsstättenverordnung: Die folgenden Arbeitsstättenrichtlinien gibt es für Toilettenräume und andere Sanitärräume-*германаар*
https://www.juraforum.de/lexikon/toilettenraeume

Цаашаа 30 ажилтан тутамд дор хаяхад 1 суултуур болон 90 ажилтан тутамд 1 угаалтуур нэмнэ.

Цаашдын чиг хандлага. Германы Үндсэн хуулийн 3 дахь заалтын 3 дахь хэсэгт зааснаар хүйсээр ялгаварлан гадуурхахыг хориглосон байна. Тэгш эрхийг хангах ерөнхий хуулийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Берлин хотын Ялгаварлан гадуурхлын эсрэг-Тэгш эрхийг хангах муж улсын албаны зүгээс хүйсээр ялгаварласан АЦӨ-г хорогдуулах ажлыг 2018 онд эхлүүлээд байна.

Хөдөлмөрийн эрх зүйд хамаарах акт болох Ажлын байрны дүрэмд “АЦӨ-г эрэгтэй, эмэгтэй гэж тусад нь байлгах буюу тусдаа ашиглах боломж олгоно” гэж АЦӨ-г заавал хүйсээр ялгаатай тусад нь байлгахыг албадан журамлаагүй боловч салангид ашиглах боломжийг хангах үүргийг тогтоосон байна. Энэ нь ганцаарчилсан бүхээг байдлаар шийдэгдэж байна.

Ажлын байрны дүрэм (АБД) нь сургуулийн АЦӨ-г хамруулан бүх ажлын байранд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Ийнхүү АБД нь транс (хүйс сольсон. ГА) болон интер (манин. ГА) болон хоёрдмол бус хүмүүст бүх хүйсийн зориулалттай АЦӨ ашиглах боломж олгож байгаа нь давуу талтай юм.

Түүнчлэн Ажлын байрны техникийн журам (ASR 4.1)-д “Хэрэв цагийн хаваарийн дагуу тусдаа ашиглах боломж бүрдүүлбэл, ажил олгогч нь эрэгтэй, эмэгтэй гэж тусад нь АЦӨ байгуулах шаардлагагүй” гэж заасан байна. Техникийн журам нь эрх зүйн хариуцлага хүлээх чадамжгүй хэдий ч энэ нь ажил олгогчид АБД зөрчихгүйгээр АЦӨ-г төлөвлөх боломж олгож байна.

Зочид буудлын барилгын дүрэм (ЗББД) нь Холбооны Улсын түвшинд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд уг дүрмийн 26 дахь заалтын 5 дахь хэсэгт заасан “Эмэгтэй, эрэгтэй АЦӨ-г ... ханаар өөр хооронд нь тусгаарлана” гэж заасан байгаа нь АЦӨ-г олон тасалгаатай байх боломжийг тусгасан байна. Хэрэв 2 хүйсээс гадна бүх хүйсэнд тохирсон нэмэлт тасалгаа байгуулах боломжгүй бол ийнхүү хүйсийн ялгаагүй WC (Unisex) гэсэн тэмдэглэгээ хэрэглэх эрх зүйн боломж байгаа гэдгийг харуулж байна.[44]

[44] Бүхэнд ялгаварлан гадуурхалгүй АЦӨ-Diskriminierungsfreie Toilettennutzung für alle-*германаар* https://www.transinterqueer.org/diskriminierungsfreie-toilettennutzung-fuer-alle/

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

- https://www.paho.org/hq/dmdocuments/2011/Ingles.pdf

АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

- Malaysian National medicines Policy file:///Users/uurtsaikh/Desktop/malaysian-national-medicines-policy-3rd-edition-2017-2021.pdf
- Sale of Drugs Act 1952 https://leap.unep.org/countries/my/national-legislation/sale-drugs-act-1952-act-368
- Dangerous Drugs Act 1952 http://www.paclii.org/pg/legis/consol_act/dda1952180/
- Poisons Act 1952 http://www.commonlii.org/my/legis/consol_act/pa19521989196/
- Medicines (Advertisement&Sale) Act https://www.pharmacy.gov.my/v2/en/documents/medicines-advertisement-sale-act-1956-and-regulations.html
- Control of Drugs and Cosmetics Regulations https://www.yumpu.com/en/document/view/36236491/control-of-drugs-and-cosmetics-regulations-1984-revised-2009
- Registration of Pharmacists Act https://www.pharmacy.gov.my/v2/en/documents/registration-pharmacists-act-1951-and-regulations.html
- The Pharmacy Services Programme https://www.pharmacy.gov.my/v2/en/content/about-us.html
- National Pharmaceutical Regulatory Agency NPRA https://www.npra.gov.my/index.php/en/
- QUEST3+ https://www.npra.gov.my/index.php/en/regulation-basic.html
- Allied Chemists Laboratory Sdn Bhd https://alliedchemists.com.my/company/laboratory-in-johor-bahru/
- Австрали Улс: https://en.wikipedia.org/wiki/Australia#Etymology
- Австрали Улсын Хүний эрхийн хороо: https://humanrights.gov.au/our-work/education/human-rights-australia
- Хүний ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрх: https://www.ohchr.org/en/water-and-sanitation/about-water-and-sanitation#:~:text=On%2028%20July%202010%2C%20the,RES%2F64%2F292).
- Австрали Улсын хууль тогтоомж: https://www.legislation.gov.au/Home
- Австрали Улс ба хүний эрхийн гэрээ конвенцууд: https://humanrights.gov.au/sites/default/files/content/education/hr_explained/download/FS7_Australia.pdf
- Австрали Улсын Хүний эрхийн хороо: https://humanrights.gov.au/our-work/rights-and-freedoms/how-are-human-rights-protected-australian-law#:~:text=These%20are%20the%20right%20to,of%20residency%20(Section%20117).
- Австрали Улсын Барилгын дүрмийн зөвлөл: https://www.abcb.gov.au/
- Австрали Улсын Үндэсний барилгын дүрэм(1-р ботийн F4 хэсэг): https://ncc.abcb.gov.au/editions/ncc-2022/adopted/volume-one/f-health-and-amenity/part-f4-sanitary-and-other-facilities
- Австрали Улсын Үндэсний барилгын дүрэм(1-р ботийн хавсралтын F2 хэсэг): https://ncc.abcb.gov.au/editions/2019-a1/ncc-2019-volume-one-amendment-1/section-f-health-and-amenity/part-f2-sanitary-and-dts
- The National Public Toilet Map: https://toiletmap.gov.au

- Австрали Улсын стандарт: https://www.standards.org.au/
- Өмнөд Австрали Мужийн Нийтийн эрүүл мэндийн ерөнхий дүрэм: https://www.legislation.sa.gov.au/__legislation/lz/c/a/south%20australian%20public%20health%20act%202011/current/2011.21.auth.pdf
- Өмнөд Австрали Мужийн “Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжаар хангах практикийн дүрэм”: https://www.sahealth.sa.gov.au/wps/wcm/connect/df72a18047b216389e61de7c69742d6b/17178.2+Sharps+Disposal+Code+A4+Booklet-ONLINE.PDF?MOD=AJPERES&CACHEID=ROOTWORKSPACE-df72a18047b216389e61de7c69742d6b-nKLanMg

ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛС

- Public health Act 1936 https://www.legislation.gov.uk/ukpga/Geo5and1Edw8/26/49/part/II/crossheading/public-sanitary-conveniences/enacted?view=plain
- Sanitary installations standart BS6465-1 https://www.en-standard.eu/bs-6465-1-2006-a1-2009-sanitary-installations-code-of-practice
- British Standart Sanitary installations BS6465 https://documents.pub/document/bs-6465-3-2006-sanitary-installations-selection-installation-and-maintenance
- The British Toilet Association http://www.btaloos.co.uk/
- A Code of Practice for Public Toilets in Britian https://waterfund.go.ke/sanitation/Downloads/5.%20A%20Code%20of%20Practice%20for%20Public%20Toilets%20in%20Britain.pdf
- Public toilets:the need for compulsory provision https://www.icevirtuallibrary.com/doi/10.1680/muen.2004.157.2.77
- Changing Places Toilets https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/818416/Changing_Places_Toilets_consultation.pdf
- The Provision of Public Toilets https://publications.parliament.uk/pa/cm200708/cmselect/cmcomloc/636/636.pdf
- Toilet Provision in Premises open to the Public https://www.north-norfolk.gov.uk/media/1831/publictoiletpolicy2014.pdf
- Sanitary installations-Code of pratice for the design of sanitary https://knowledge.bsigroup.com/products/sanitary-installations-code-of-practice-for-the-design-of-sanitary-facilities

БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

- A Guide to Better Public Toilet Design and Maintenance https://www.toilet.org.sg/articles/GuideBetterPublicToilet.pdf
- Code of practice on environmental health https://www.nea.gov.sg/docs/default-source/resource/practices-/copeh-2021.pdf
- Restroom Association of Singapore (RAS) https://toilet.org.sg/
- On-site Training Programme (OTP) on Restroom Cleaning https://toilet.org.sg/on-site-training
- National Environment Agency (NEA) National Environment Agency (NEA)
- STAR Awards Programme https://toilet.org.sg/starawards
- Happy toilet programme https://www.toilet.org.sg/docs/HTPBrochure.pdf

ЯПОН УЛС

- Japan Toilet Association-JTA https://j-toilet.com/english/

- Japan Toilet Labo-https://www.toilet.or.jp/about/
- Japanese Industrial Standarts Committee-JISC https://www.jisc.go.jp/jisc/index.html
- Japanese Industrial Standarts-JIS https://www.sanitary-net.com/trend/standard.html
- International Organization for Standardization-ISO https://www.iso.org/home.html
- Үйлдвэрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=347AC0000000057
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай журам https://elaws.e-gov.go.jp/document?lawid=347M50002000032

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

- Korean public toilet improvement experience and its implications, 2014, Ministry of Strategy and finance, KDI school. https://archives.kdischool.ac.kr/bitstream/11125/42118/1/%282014%29%20Modularization%20of%20Korea%27s%20development%20experience_Korean%20public%20toilet%20improvement%20experience%20and%20its%20implications.PDF
- Public toilets act https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55680&lang=ENG
- Korean toilet association http://www.toilet.or.kr/

ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

- Ариун цэврийн өрөө-Toilette-германаар https://de.wikipedia.org/wiki/Toilette
- Сургуулийн эрх зүй: Сургуульд АЦӨ орохыг хориглох нь үндэстэй юу?-Schulrecht - Toilettenverbot an der Schule rechtsmäßig?-германаар https://www.anwalt.de/rechtstipps/schulrecht-toilettenverbot-an-der-schule-rechtsmaessig_060575.html#:~:text=Jedermann%20hat%20das%20Recht%2C%20nicht,2%20GG%20(Grundgesetz)%20abgesichert.
- Нийтийн хоолны академи-Gastro academy-германаар https://www.gastro-academy.com/gruenden/gesetze-vorschriften/toilettenpflicht/#:~:text=Betriebe%2C%20in%20denen%20Alkohol%20ausgeschenkt,50%20Sitzpl%C3%A4tze%20f%C3%BCr%20G%C3%A4ste%20bieten.
- Ажлын байрны дүрэм: АЦӨ болон бусад эрүүл ахуйн өрөөнд тавигдах ажлын байрны шаардлага, нөхцөл-Arbeitsstättenverordnung: Die folgenden Arbeitsstättenrichtlinien gibt es für Toilettenräume und andere Sanitärräume-германаар https://www.juraforum.de/lexikon/toilettenraeume
- Бүхэнд ялгаварлан гадуурхалгүй АЦӨ-Diskriminierungsfreie Toilettennutzung für alle-германаар https://www.transinterqueer.org/diskriminierungsfreie-toilettennutzung-fuer-alle/

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Зүүн өмнөд Азийн орнуудын холбооны Нийтийн ариун цэврийн өрөөний стандарт (ASEAN Public toilet standart)


Illustrations 1, 2, 3: Signages on passageway; Signage at toilet premise







Illustrations 4, 5, 6: Maze Entry; Privacy entry (should avoid urinals reflecting mirrors); modesty boards








Illustrations 7, 8, 9: Baby changing/breast feed facility; Multipurpose handicap toilet room & signage







Illustrations 10, 11, 12: Accessible toilet design (BS8300 - 2001); Accessible toilet; Ambulant toilet







Illustrations 13, 14 and 15: Accessible toilet design for kids: Washbasin; Urinal; WC seat cover








Illustrations 16, 17 and 18: Considerations for water use and resource (i.e. paper) saving







Illustrations 19, 20, 21: Muslim wash urinal; Ablution area; WC with hose and nozzle







Illustrations 22, 23, 24: Squatting pan signage; Horse-shoe sitting pan for male WCs





